



БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,  
СПОРТЫН ЯАМ



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН ЯАМ

ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ БОЛОВСРОЛ ШААРДЛАГАТАЙ ХҮҮХДЭД ҮЗҮҮЛЭХ  
ЭРҮҮЛ МЭНД, БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН  
ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ



СУРАЛЦАХУЙН БЭРХШЭЭЛТЭЙ,  
ЗАН ҮЙЛИЙН АСУУДАЛТАЙ  
ХҮҮХДЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ  
АРГА ЗҮЙН ЗӨВЛӨМЖ

Улаанбаатар хот  
2019

ННА-74.3  
ДАА-371.9  
Х-Б-146

**Хянасан:**

МУБИС, Боловсрол судлалын сургуулийн тусгай хэрэгцээт  
боловсролын тэнхмийн эрхлэгч дэд.проф.доктор Ph.D Г.БАТЦЭНГЭЛ

**Хамтран ажилласан:**

Ерөнхий боловсролын 70 дугаар тусгай сургуулийн согог зүйч багш	Б.ЭНХТУЯА
Ерөнхий боловсролын 16 дугаар сургуулийн сургалтын менежер	Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Ерөнхий боловсролын 35 дугаар сургуулийн бага боловсролын багш	Б.АМАРМЭНД
Ерөнхий боловсролын 79 дүгээр сургуулийн сургалтын менежер	Б. АРИУНБИЛЭГ
Ерөнхий боловсролын 111 дүгээр сургуулийн химийн багш	Г.ГАУКАР
Ерөнхий боловсролын 28 дугаар сургуулийн англи хэлний багш	Д.БАЙГАЛМАА
Ерөнхий боловсролын 113 дугаар сургуулийн бага боловсролын багш	Л.ЛХАМЖАВ
Ерөнхий боловсролын 34 дүгээр сургуулийн бага боловсролын багш	Г.ДАШМАА
Ерөнхий боловсролын 26 дугаар сургуулийн бага боловсролын багш	А.ЭРДЭНЭТУЯА
Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын “Ирээдүй” цогцолбор сургууль	
Бага боловсролын багш	Д.ДЭЖИДМАА
Биеийн тамирын багш	Б.ЦЭРЭННАДМИД
Монгол хэл уран зохиолын багш	Г.ГЭРЭЛМАА
Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын “Титэм” дунд сургууль Математикийн багш	Б.САЙХАНЦЭЦЭГ
Физикийн багш	Г.ЖАВЗАНДУЛАМ
Химийн багш	Б.БОЛД

ISBN: 978-9919-9519-5-5

## ГАРЧИГ

<b>I. Өмнөх үг</b>	<b>4</b>
<b>II. Суралцахуйн бэрхшээлтэй, зан үйлийн асуудалтай хүүхдийн онцлог, хэрэгцээг таних</b>	<b>5</b>
Суралцахуйн бэрхшээлтэй, зан үйлийн асуудалтай хүүхдийн онцлог хэрэгцээг таних асуулга хүснэгт	6
<b>III. Суралцахуйн бэрхшээлтэй, зан үйлийн асуудалтай хүүхдэд дэмжлэг үзүүлэх арга зүй</b>	<b>7</b>
1. Сонсох явцад үүсэх бэрхшээл	8
2. Ярих явцад үүсэх бэрхшээл	9
3. Унших явцад үүсэх бэрхшээл	10
4. Бичих явцад үүсэх бэрхшээл	11
5. Тоо бодох явцад үүсэх бэрхшээл	12
6. Цаг хугацаа, орон зай, учир зүйн холбоо хамаарлыг ойлгох явцад үүсэх бэрхшээл	13
7. Булчингийн хөдөлгөөний үед үүсэх бэрхшээл	14
8. Хүнтэй харилцах харилцааны үед үүсэх бэрхшээл	15
9а. Үйлдэл хийх /Анхаарал сарних/ үед үүсэх асуудал	16
9б. Үйлдэл хийх /Хэт, огцом хөдөлгөөнтэй/ үед үүсэх асуудал	17
<b>IV Туршилтын сургуулиуд дээрх хүүхдийн хэрэгцээнд нийцүүлж тохирох арга зүйн дэмжлэг үзүүлэн ажилласан жишээнүүд</b>	<b>18</b>

## I. ӨМНӨХ ҮГ

Багш, Таны ангид оюун ухааны хөгжлийн хувьд хоцрогдолгүй ч ном уншихдаа үг, үсгээ алгасдаг, буруу харуулж бичдэг, сонссон зүйлээ амархан мартдаг, олон удаа давтан заасан ч тоо бодож чадахгүй, хичээлийн дундуур дураараа гарч гүйдэг хүүхэд байдаг уу. Тийм бол тухайн хүүхдэд ил харагдахгүй ч ямар нэг асуудал байж болох юм.

Жишээбэл, дэвтэртээ үсгээ том, жижиг эсвэл буруу харуулж, дэвтрийн шугам, зураасыг хэтрүүлэн бичих зэрэг алдаа гаргадаг хүүхэд байна гэж бодъё. Зөв бичихийн тулд эхлээд үзгээ зөв барих, үсгээ зөв холбох, үгийн хооронд зай авах, жигд бичих зэрэг чадвар хэрэгтэй. Хэрвээ хүүхэд, эдгээр чадваруудыг эзэмшиж дадаагүй бол багш, учир шалтгааныг нь олж тухайн хүүхдэд тохирсон дэмжлэгийг үзүүлснээр ахиц гарч байгааг нь мэдэх боломжтой.

Энэхүү арга зүйн зөвлөмжийг ерөнхий боловсролын сургуулийн багш нарт зориулсан бөгөөд асуудалтай хүүхдийн онцлогийг таньж мэдэх энгийн асуулга, дэмжлэг үзүүлэн ажиллах арга зүйн санал зөвлөмж, мөн төслийн хүрээнд хамтарч ажилласан туршилтын сургуулиудын багш нарын ажилласан бодит жишээ зэргийг оруулсан.

## II. СУРАЛЦАХУЙН БЭРХШЭЭЛТЭЙ, ЗАН ҮЙЛИЙН АСУУДАЛТАЙ ХҮҮХДИЙН ОНЦЛОГ, ХЭРЭГЦЭЭГ ТАНИХ

Энэхүү арга зүйн зөвлөмж нь сургуулийн өдөр тутмын амьдралд хичээл дээр ямар нэг асуудалтай тулгарч байгаа хүүхдийн онцлог, хэрэгцээ, шаардлагыг олж мэдэхэд зориулагдсан. Харин хөгжлийн бэрхшээлийг тодорхойлох зорилго агуулаагүй болно.

### АСУУЛГЫГ БӨГЛӨХ БОЛОН АНХААРАХ ЗҮЙЛС

1. Асуулгын нэг нүүрэнд 4 хүртэлх хүүхдийн мэдээллийг оруулах боломжтой. Багш өөртөө ойлгомжтой байхаар тэмдэглэгээг хийнэ / Журналын нэрсийн дугаар эсвэл нэрийн эхний үсэг г.м/
2. Багш асуулгыг бөглөх үед хүүхэд хамт байх шаардлагагүй.
3. Асуулгыг “Сонсох”, “Ярих”, “Унших”, “Бичих”, “Тоо бодох”, “Цаг хугацаа, орон зай, учир шалтгааны холбоо хамаарлыг ойлгох”, “Булчингийн хөдөлгөөн”, “Хүнтэй харилцах харилцаа”, “Үйлдэл хийх” гэсэн хөгжлийн айлнд хувааж дараах байдлаар оноо өгнө.
  - “Чадна ”→ 4
  - “Бага зэрэг чадна”→ 3
  - “Бараг чадахгүй”→ 2
  - “Огт чадахгүй”→ 1
4. Хүүхдийн бодит байдлыг дүгнэхдээ, үе тэнгийн хүүхдүүдтэй нь харьцуулан бодож оноо өгч асуулгыг бөглөнө.
5. Асуумж бүрт заавал оноо өгнө.
6. “Бараг чадахгүй /2/”, “Огт чадахгүй/1/” гэсэн оноо өгсөн тохиолдолд 7 дугаар хуудаснаас хойш байгаа ай тус бүр дэх дэлгэрэнгүй дэмжлэгийн агуулгаас санаа авч, сургуулийн орчинд хэрхэн дэмжих тухай судалж үзнэ.
7. Асуумж бүрт өгсөн оноо нь хүүхэд тус бүрийн хэрэгцээ, шаардлагыг олж мэдэх, тодорхой арга зүйг сонгон ажиллахад багшид туслах зорилготой. Харин аливаа нэг шийдвэр, оношийн үзүүлэлт биш гэдгийг сайтар анхаарна уу.
8. Хүүхдийн талаарх хувь хүний мэдээллийг нууцалж, шаардлагатай тохиолдолд зөвхөн эцэг эх, асран хамгаалагч нарт үзүүлж мэдээлэл өгч болно.

**СУРАЛЦАХУЙН БЭРХШЭЭЛТЭЙ, ЗАН ҮЙЛИЙН АСУУДАЛТАЙ ХҮҮХДИЙН ОНЦЛОГ  
ХЭРЭГЦЭЭГ ТАНИХ АСУУЛГА**

Анги:					
	АГУУЛГА	Хүүхэд 1	Хүүхэд 2	Хүүхэд 3	Хүүхэд 4
<b>① Сонсох</b>					
1	Анхаарлаа төвлөрүүлэн харилцагчийн яриаг сонсож чадна				
2	Сонссон зүйлээ мартахгүй тогтоож чадна				
3	Ганцаарчлан эсвэл хамт олон багаар нь даалгавар, заавар өгөхөд ойлгож гүйцэтгэж чадна				
4	Ангид яригдаж байгаа зүйлийг сайн ойлгож, идэвхтэй оролцоно				
<b>② Ярих</b>					
1	Ангийн хүүхдүүдийн түвшинд эсвэл тэднээс илүү үгийн сантай				
2	Хэл зүйн дүрмийн хувьд алдаагүй бүтэн өгүүлбэрээр ярина				
3	Дараалал, учир шалтгааны холбоо хамаарлыг тогтоож, өөрийн туршлага болон санал бодлоо илэрхийлж чадна				
4	Үе тэнгийн хүүхдүүдтэй яриа өрнүүлж чадна.				
<b>③ Унших</b>					
1	Цагаан толгойн үсэг бүрийг мэднэ (Жишээлбэл: А үсгийг хараад А гэж уншдаг)				
2	Цагаан толгойн үсгийн дуудлагыг нэг нэгээр нь мэднэ. (Жишээлбэл: А үсгийн А гэсэн дуудлагыг хэлж чадна)(Авиан дуудлагын бэрхшээлийг тооцохгүй)				
3	Урт, хос эгшиг, Я-гийн төрлийн үсэг орсон үе болон үгийг алдаагүй уншина.				
4	Үсэг алгасах, тааж унших зэрэг алдаа гаргалгүй чанга дуугаар түгдрэлгүй уншина. (ээрдэг хүүхдийг тооцохгүй )				
5	Бичмэл болон дармал үсэгнээс зөв уншиж чадна.				
<b>④ Бичих</b>					
1	Цагаан толгойн үсгийг сонсоод зөв бичиж чадна				
2	Үг, өгүүлбэрийг сонсоод зөв бичиж чадна				
3	Урт, хос эгшиг, Я-гийн төрлийн үсэг орсон үе, үгийг сонсоод алдаагүй бичнэ				
4	Бичиглэл төстэй үсгүүдийг хольж солихгүйгээр зөв бичиж чадна. (Жишээлбэл: н-п, бичмэлээр том Р-Г)				
5	Үсэгнүүдийг бичмэл, дармалаар зөв бичиж чадна				
<b>⑤ Тоо бодох</b>					
1	Хуруугаараа тоолохгүйгээр 10-ын дотор нэмж, хасч чадна				
2	Орон хэтрүүлэн нэмэх, орон шилжүүлэн хасах үйлдлийг ангийн хүүхдүүдтэй ижил түвшинд бодож чадна				
3	Ангийн хүүхдүүдтэй ижил түвшинд өгүүлбэртэй бодлого бодож чадна				
4	Хүрдээ цээжилсэн				
<b>⑥ Цаг хугацаа, орон зай, учир шалтгааны холбоо хамаарлыг ойлгох</b>					
1	Яагаад ийм зүйл болсон тухай шалтгааныг зөв ойлгож чадна				
2	Байрлал, орон зайг илэрхийлсэн үг хэллэг (баруун зүүн тал, зүүн баруун өмнөд хойд зүг гэх мэт)-ийг зөв ойлгодог				
3	Дүрсийг зөв хуулж зурж чадна				
4	Цаг хараад зөв хэлж чаддаг, цаг хугацаа заасан үг хэллэгийг зөв ойлгодог				
<b>⑦ Булчингийн хөдөлгөөн</b>					
1	Хайч барих, товч товчлох зэрэг гарын жижиг булчингийн хөдөлгөөнөөр хийдэг үйлдлийг эвлэг хийж чаддаг				
2	Үсэг, үгийг элементийн дагуу сайхан бичиж чаддаг				
3	Дээс тоглох, бөмбөг шидэхдээ ангийн хүүхдүүдийн ижил түвшинд хийж гүйцэтгэж чадна				
4	Турник болон матраас дээр хийдэг дасгалуудыг ангийн хүүхдүүдтэй ижил түвшинд хийж чадна				
<b>⑧ Хүнгэй харилцах харилцаа</b>					
1	Завсарлагааны үеэр болон хичээлийн дараа найзуудтайгаа тоглоно				
2	Дүрмийг мөрдөж тоглож чадна				
3	Харилцаж байгаа хүүхэддээ санаа тавьж, хамтран үйл ажиллагаа хийж чадна				
4	"Тур өгч байгаач", "Баярлалаа", "Уучлаарай" зэрэг үгийг зөв хэрэглэж чадна				
<b>⑨ Үйлдэл хийх</b>					
1	Зорилгодоо хүрэх төлөвлөгөө гаргана, заавар аваагүй ч зохих ёсоор нь үйлдэл хийж чадна.				
2	Сонирхлоо бууруулахгүй, биеэ зайлах зэрэг хөдөлгөөн хийлгүй асуудалд төвлөрч чадна.				
3	Мартаж эсвэл алдаж гээлгүйгээр эд юмсаа авч явах, эргэн тойрондоо тараахгүйгээр юмаа цэгцэлж чадна.				
4	Өөрийн дураар, эмх замбараагүй ярихгүй, эсрэг хүний яриаг дуустал сонсож чадна.				
5	Сэтгэлийн хөөрөлд авталгүй тайван байж үйлдэл хийж чадна.				
6	Гэнэтийн үйл явдал тохиолдоход сэтгэл санаагаа удирдаж, өөрчилж чадна.				
<b>НИЙТ</b>					

**III. СУРАЛЦАХУЙН  
БЭРХШЭЭЛТЭЙ, ЗАН ҮЙЛИЙН  
АСУУДАЛТАЙ ХҮҮХДЭД  
ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ АРГА ЗҮЙ**



## 1 Сонсох явцад үүсэх бэрхшээл

### Онцлог шинж

- Анхаарлаа төвлөрүүлэн харилцагчийн яриаг сонсож чадахгүй
- Нэг сонссон зүйлээ байнга тогтоодоггүй, мартдаг.
- Өгсөн даалгавар, зааврын агуулгыг ойлгож хийж чаддаггүй.
- Анги дотор яригдаж байгаа зүйлд оролцдоггүй.
- Буруу сонсох тохиолдол их.

### Боломжит шалтгаан

- Сонголоор хүлээн авсан мэдээллийг уураг тархиндаа сайтар боловсруулж, ойлгож чаддаггүй.
- Сонссон зүйлээ зөв тогтоон цээжилж чаддаггүй /Богино хугацааны ой тогтоолт муу/.
- Сонголын хувьд асуудалтай /Энэ тохиолдолд эмнэлэгт үзүүлээрэй/.

### Багшлах болон дэмжлэг үзүүлэх арга зүйн санал, зөвлөмж

Багшийн зүгээс анхаарах, болон хийх зүйл	<ul style="list-style-type: none"><li>- Анги нийтэд мэдээлэл өгөх үед тухайн хүүхэд анхаарлаа төвлөрүүлэн сонсож чадахгүй тохиолдолд багш руу харахыг сануулж, түүн рүү харангаа ярих.</li><li>- Хүүхэд, сонголоор мэдээлэл хүлээн авах боломжийг багасгах үүднээс, хараад ойлгох боломжтой зурган карт, эсвэл бичиж үзүүлэх.</li><li>- Нэг дор олон мэдээлэл өгөх биш, богино өгүүлбэрээр нэг бүрчлэн тайлбарлаж, хүүхдээс ойлгосон эсэхийг лавлан асуух</li><li>- Эхний ширээнд суулгах.</li><li>- Хүүхдэд ойлгомжтой, оновчтой үгээр ярих</li></ul>
Хүүхдэд өгөх зөвлөмж	<ul style="list-style-type: none"><li>- Харилцаж байгаа хүний нүүр рүү харуулах.</li><li>- Ойлгоогүй зүйлээ “Багшаасаа асууж байгаарай” гэж хэлэх.</li><li>- Тэмдэглэлийн дэвтэр биедээ байнга авч явахыг сануулах.</li><li>- Сонссон зүйлээ мартахагүйн тулд дэвтэрт нь бичүүлж байх. Хүүхэд бичиж авахад хялбар байдлаар, гол зүйлээ ойлгомжтой, тодорхой хэлэх.</li></ul>



## 2

### Ярих явцад үүсэх бэрхшээл

#### Онцлог шинж

- Самбарт бичсэн үсгийг хараад хуулж бичиж чадахгүй.
- Дэвтрийн шугамнаас хэтрүүлж бичдэг.
- Цээжээр бичихдээ алддаг.
- Үсгээ эсрэгээр нь харуулан бичдэг.
- Ижил төстэй үсгийг ялгаж бичиж чаддаггүй. Буруу бичдэг.

#### Боломжит шалтгаан

- Үсгийн зурлагыг цээжлээгүй.
- Хуулан бичих хэсэг нь аль болохыг ойлгодоггүй.
- Анхаарал тогтворгүйгээс алдаж бичдэг.
- Сонссон зүйлээ бичиж чаддаггүй.
- Буруу суудаг, үзгээ буруу барьдаг.

#### Багшлах болон дэмжлэг үзүүлэх арга зүйн санал, зөвлөмж

Багшийн зүгээс анхаарах болон хийх зүйл	<ul style="list-style-type: none"><li>- Шаардлагатай тохиолдолд элементийн дэвтэр дээр үргэлжлүүлэн бичүүлнэ.</li><li>- Хүүхэд самбараас хуулахад ойлгомжтой байхаар самбараас төлөвлөж бичиглэл хийх.</li><li>- Самбараас хуулж бичих хэсгийг цаасан дээр хэвлэж, ойроос харж дэвтэртээ бичих боломжийг бүрдүүлэх.</li></ul>
Хүүхдэд өгөх зөвлөмж	<ul style="list-style-type: none"><li>- Хүүхэд зөв сууж, үзгээ зөв барьсан байх.</li><li>- Үсгийг бүдэг зураад, хүүхдээр давхарлуулан бичүүлэх.</li><li>- Хүүхэд амандаа уншингаа бичих.</li></ul>

### 3

## Унших явцад үүсэх бэрхшээл

### Онцлог шинж

- Цагаан толгойн үсгээ зөв дуудаж чаддаггүй.
- Урт, хос эгшиг, Я-гийн төрлийн үсэг орсон үе болон үгийг зөв дуудаж уншиж чаддаггүй.
- Үсэг алгасах, тааж унших зэрэг алдаа гаргадаг.
- Өгүүлбэрийг уншиж агуулгыг зөв ойлгож чаддаггүй.

### Боломжит шалтгаан

- Үсгээ нүдлээгүй.
- Үсгийг буруу дууддаг.
- Үсэг холбож үе бүтээж уншиж чадахгүй.
- Уншиж байгаа зүйлээ хараагаараа гүйлгэж чаддаггүй.
- Ойлгож уншдаггүй /зөвхөн үсэгний хэлбэр, үсэг хоорондын зайд анхаардаг/.
- Өгүүлбэр хоорондын уялдаа холбоог ойлгодоггүй.

### Багшлах болон дэмжлэг үзүүлэх арга зүйн санал, зөвлөмж

Багшийн зүгээс анхаарах болон хийх зүйл	<ul style="list-style-type: none"><li>- Цагаан толгойн бүх үсэг, үетэй зурган картыг нэг нэгээр нь үзүүлж хамт хэлнэ.</li><li>- Урт, хос, туслах эгшгийг тодруулж, анхааруулах.</li><li>- Үсэгний хэмжээ, үг хоорондын зайг уншихад хялбар байхаар шийдэж өгөх.</li></ul>
Хүүхдэд өгөх зөвлөмж	<ul style="list-style-type: none"><li>- Уншиж байгаа мөрийг хуруугаар дагуулан зааж уншуулах.</li><li>- Нүхэлсэн цаас ашиглаж, тухайн уншиж байгаа мөр нь харагдахуйц байдлаар шийдэх.</li><li>- Үгийг уншиж сурсны дараа тухайн үг орсон өгүүлбэр уншуулах.</li><li>- Уншиж байгаа зүйлийн гол хэсгийг тодруулж өгөх.</li></ul>

## 4

### Бичих явцад үүсэх бэрхшээл

#### Онцлог шинж

- Самбарт бичсэн үсгийг хараад хуулж бичиж чадахгүй.
- Дэвтрийн шугамнаас хэтрүүлж бичдэг.
- Цээжээр бичихдээ алддаг.
- Үсгээ эсрэгээр нь харуулан бичдэг.
- Ижил төстэй үсгийг ялгаж бичиж чаддаггүй. Буруу бичдэг.

#### Боломжит шалтгаан

- Үсгийн зурлагыг цээжлээгүй.
- Хуулан бичих хэсэг нь аль болохыг ойлгодоггүй.
- Анхаарал тогтворгүйгээс алдаж бичдэг.
- Сонссон зүйлээ бичиж чаддаггүй.
- Буруу суудаг, үзгээ буруу барьдаг.

#### Багшлах болон дэмжлэг үзүүлэх арга зүйн санал, зөвлөмж

Багшийн зүгээс анхаарах болон хийх зүйл	<ul style="list-style-type: none"><li>- Шаардлагатай тохиолдолд элементийн дэвтэр дээр үргэлжлүүлэн бичүүлнэ.</li><li>- Хүүхэд самбараас хуулахад ойлгомжтой байхаар самбараа төлөвлөж бичиглэл хийх.</li><li>- Самбараас хуулж бичих хэсгийг цаасан дээр хэвлэж, ойроос харж дэвтэртээ бичих боломжийг бүрдүүлэх.</li></ul>
Хүүхдэд өгөх зөвлөмж	<ul style="list-style-type: none"><li>- Хүүхэд зөв сууж, үзгээ зөв барьсан байх.</li><li>- Үсгийг бүдэг зураад, хүүхдээр давхарлуулан бичүүлэх.</li><li>- Хүүхэд амандаа уншингаа бичих.</li></ul>

## 5

### Тоо бодох явцад үүсэх бэрхшээл

#### Онцлог шинж

- Хялбар бодлого бодож чадахгүй.
- Цээжээр бодож чаддаггүй.
- Багана бичиглэл хийхдээ орон алдаж бичдэг.
- Үйлдэл хийхдээ санасан болон орон шилжүүлсэн тоогоо мартдаг.
- Өгүүлбэртэй бодлого бодож чадахгүй.

#### Боломжит шалтгаан

- Тооны утгыг ойлгохгүй.
- Үйлдлийн дарааллыг мэдэхгүй.
- Цээжээр бодож чадахгүй.
- Өгүүлбэртэй бодлогын нөхцлөөр бичиглэл хийж чадахгүй.

#### Багшлах болон дэмжлэг үзүүлэх арга зүйн санал, зөвлөмж

Багшийн зүгээс анхаарах болон хийх зүйл	<ul style="list-style-type: none"><li>- Биет болон биет бус хэрэглэгдэхүүн ашиглан тоо бодуулах.</li><li>- Орон алгасуулахгүй байх үүднээс нэг нүдэнд нэг тоо бичүүлэх.</li><li>- Бодлого бодохдоо удаан бол цөөн бодлого хэвлэж өгөх.</li><li>- Өгүүлбэртэй бодлогыг зургаар илэрхийлэх.</li></ul>
Хүүхдэд өгөх зөвлөмж	<ul style="list-style-type: none"><li>- Бодолт хийхэд нь туслах зорилгоор савх зэрэг бодит хэрэглэгдэхүүн ашиглах.</li><li>- Зөвхөн цээжээр бус цаасан дээр бичүүлж бодуулах.</li><li>- Өгүүлбэртэй бодлогын гол хэсгийг тодруулах.</li></ul>

## 6

### Цаг хугацаа, орон зай, учир шалтгааны холбоо хамаарлыг ойлгох явцад үүсэх бэрхшээл

#### Онцлог шинж

- Цаг хараад зөв ойлгож, хэлж чаддаггүй /жишээ нь: 1 цаг 40 минут/-ийг зөв ойлгодоггүй.
- Зураг болон дүрс зурж чаддаггүй.
- Замдаа төөрдөг.
- Схем зураг уншиж ойлгодоггүй.
- Тухайн зүйл болсон учир шалтгаан, холбоо хамаарлыг ойлгодоггүй..

#### Боломжит шалтгаан

- Харсан зүйлээ танин мэдэх чадвар сул.
- Орон зайн байрлал, хамаарлыг сайтар ойлгодоггүй.
- Зураг, дүрс, биетийг хараад таньж, нэрлэн зурж, бүтээх чадвар сул
- Цаг хугацаа илэрхийлсэн үгийн ухагдахуун /минут, цаг, өдөр, гараг г.м/-ыг ойлгоогүй.
- Харсан, сонссон зүйлээ ойлгож шийдвэр гаргах чадвар сул.

#### Багшлах болон дэмжлэг үзүүлэх арга зүйн санал, зөвлөмж

Багшийн зүгээс анхаарах болон хийх зүйл	<ul style="list-style-type: none"><li>- Хичээл эхлэх, дуусах хугацааг аналог цагаар харуулах.</li><li>- Цагийн урт, богино зүүний байрлалд анхаарлыг нь хандуулж, цаг заах.</li><li>- Цаг тооны бичиг үзүүлж өдөр, гарагийг тайлбарлаж өгөх</li><li>- Дүрсийг үгээр тайлбарлаж өгөх.</li><li>- Хялбар дүрсээс эхлэн бага багаар хүндрүүлсэн зураг зурахад нь туслах.</li><li>- Зургийг цэвэр нямбай зурж чадахгүй байсан ч ерөнхий дүрслэлийг гаргаж зурсан бол зөв гэж үнэлэх.</li><li>- Тухайн болсон зүйлийн холбоо хамаарлыг үгээр тайлбарлаж өгөх.</li><li>- Хэрэглэгдэхүүний байрыг зургаар зааж өгнө.</li><li>- Схем зураг дээр гол зүйлийг нь тодруулж өгөх.</li></ul>
Хүүхдэд өгөх зөвлөмж	<ul style="list-style-type: none"><li>- Цагийн зүүний байрлалыг хэлэх.</li><li>- 2 дүрсний ялгааг хэлэх.</li><li>- Хялбар дүрсийг харж дуурайлган зурах.</li><li>- “Яагаад ийм болсон”, “Үүний дараа юу болох” тухай бодуулах.</li></ul>

## 7

### Булчингийн хөдөлгөөний үед үүсэх бэрхшээл

#### Онцлог шинж

- Матраас дээр дасгал хийх үедээ тэнцвэрээ алддаг.
- Сандал дээр тогтвортой суудаггүй.
- Бөмбөг шидэж, тосож авч чаддаггүй.
- Хайчлах, товч товчлох, тайлах, үдээс үдэх зэрэг үйлдлийг сайн хийж чаддаггүй.
- Бичгийн хэв ойлгомжгүй.

#### Боломжит шалтгаан

- Сандрах, хичээх үед булчин чангардаг эсвэл сулардаг.
- Хөдөлгөөний эвсэлгүй.
- Нүдний болон гарын хөдөлгөөн нь зөрдөг.

#### Багшлах болон дэмжлэг үзүүлэх арга зүйн санал, зөвлөмж

Багшийн зүгээс анхаарах болон хийх зүйл	<ul style="list-style-type: none"><li>- Савлах, найгах, тэнцвэр олох дасгал даалгаврыг идэвхтэй хийлгэх.</li><li>- Өөрийн биеийг удирдах дасгал даалгаврыг идэвхтэй хийлгэх.</li><li>- Сандал дээр суухад эвтэйхэн байхаар өндөр намыг тохируулах, хөлөн доор нь гишгүүр тавьж өгөх.</li><li>- Гарын жижиг булчинг хөгжлүүлэх үйлдэл хийлгэх / Хайчлах, товч товчлох г.м/.</li></ul>
Хүүхдэд өгөх зөвлөмж	<ul style="list-style-type: none"><li>- Биеийн хөдөлгөөний дасгал гүйцэтгэхдээ хурд гэхээсээ илүү зөв хийлгүүлэх, ойлгуулах /Удаан ч байсан хамаагүй хамгийн гол нь зөв хийх/.</li><li>- Сандал дээр гүйцэд цэх суулгах.</li><li>- “Харж байгаад зөв товчил”, “Харж байгаад зөв хайчил” гэж хэлэх.</li></ul>

## 8

### Хүнтэй харилцах харилцааны үед үүсэх бэрхшээл

#### Онцлог шинж

- Тоглоомын дүрэм баримталж тоглож чаддаггүй.
- Найзынхаа дэргэд байгаа ч ганцаараа тоглодог.
- Өөрийн дураар үйлдэл хийдэг.
- Найзтайгаа дотно байхыг хүсдэг ч сайн харилцаа үүсгэж чаддаггүй.

#### Боломжит шалтгаан

- Харилцагчийн дохиог ойлгодоггүй. Нүүрний хувирал, сэтгэл хөдлөлийн байдал зэргийг уншиж ойлгож чаддаггүй.
- Тоглоомын дүрмийг ойлгохдоо тааруу.
- Найзтайгаа хэрхэн харилцахаа мэдэхгүй.
- Үгийг ойлгох чадвар, илэрхийлэх чадвар сул.

#### Багшлах болон дэмжлэг үзүүлэх арга зүйн санал, зөвлөмж

Багшийн зүгээс анхаарах болон хийх зүйл	<ul style="list-style-type: none"><li>- Багш өөрөө хүүхэдтэй хамт хялбар дүрэмтэй тоглоом тоглох</li><li>- Дүрмийг тайлбарлаж өгөх.</li><li>- Тухайн хүүхдийн сайн чаддаг тоглоомоос эхлэх.</li><li>- Харилцагчийн нүүрний хувирлаас хамаарч сэтгэл хөдлөлийн байдлыг уншиж ойлгох даалгавар өгөх.</li></ul>
Хүүхэдтэй ажиллах арга зүй	<ul style="list-style-type: none"><li>- Бэрхшээл тулгарсан үед багшдаа хэлж байхыг ойлгуулах.</li><li>- Хүүхдэд ямар нэг асуудал гарвал хамтдаа болсон явдлын талаар ярилцах, дүгнэх, шалтгааныг тодруулах, шийдвэрлэх арга замыг олох.</li></ul>

## 9а

### Үйлдэл хийх /Анхаарал сарних/ үед үүсэх асуудал

#### Онцлог шинж

- Ихэвчлэн хүний яриаг анхааралтай сонсдоггүй.
- Даалгавар, тоглоом зэрэгт анхаарлаа удаан төвлөрүүлж чаддаггүй
- Зааврын дагуу дуустал нь хийдэггүй.
- Юм мартаx, гээx нь их.
- Эмx цэгцгүй.

#### Боломжит шалтгаан

- Харах, сонсох зүйлд анхаарлаа хандуулж чадахгүй.
- Эргэн тойронд байгаа олон юмнаас болоод анхаарал нь сарнидаг.
- Анхаарлаа төвлөрүүлэх хугацаа нь богино.
- Сонссон зүйлээ ойлгох чадвар сул.
- Анхаарлаа хуваарилж чаддаггүй.

#### Багшлах болон дэмжлэг үзүүлэх арга зүйн санал, зөвлөмж

Багшийн зүгээс анхаарах болон хийх зүйл	<ul style="list-style-type: none"><li>- Багш ярихаасаа өмнө хүүхдийн анхаарлыг өөртөө хандуулна.</li><li>- Урт тайлбарыг хэд хэдэн богино өгүүлбэрээр илэрхийлж, хүүхдээс ойлгосон эсэхийг лавлан ярих.</li><li>- Хийх зүйлийг нь бичгээр, зурган карт, дохиогоор тайлбарлаж, хэзээ дуусах талаар ойлголт баримжаалал өгөх.</li><li>- Үйл ажиллагааг хэд хэдэн алхамд хувааж, тухайн алхам бүрт урамшуулж, дэмжлэг үзүүлэх.</li><li>- Цонх, коридорын талын суудал чимээ ихтэй, нүдэнд өртөх зүйл их тул тухайн хүүхдийг суулгахгүй байх.</li></ul>
Хүүхэдтэй ажиллах арга зүй	<ul style="list-style-type: none"><li>- Багшийн яриаг сонсохдоо сандлын түшлэгт нуруугаа наан цэх сууж, багшийн зүг рүү харж сонсоно.</li><li>- Ширээн дээр зөвхөн шаардлагатай зүйлүүдийг гаргаж, хэрэггүй зүйлийг ширээний нүд, цүнхэндээ далд хийх</li><li>- Хэрэглэсэн зүйлээ байсан газарт нь буцааж тавих.</li><li>- Ангиас гарч явахдаа юм унагасан, мартсан зүйл байхгүй эсэхийг шалгах.</li></ul>



96

## Үйлдэл хийх /Хэт хөдөлгөөнтэй/ үед үүсэх асуудал

### Онцлог шинж

- Тогтвортой сууж чаддаггүй.
- Дарааллаа хүлээж чаддаггүй.
- Ширээ, сандал дээр гарах, анги, коридороор гүйх.
- Ярьж эхэлсэн бол дуусдаггүй.
- Хичээл дундуур дураараа ярьдаг.
- Бусдад саад болдог.
- Асуулт тавьж дуусаагүй байхад хариулдаг.


### Боломжит шалтгаан

- Өөрийнхөө үйлдлийг хянах тархины үйл ажиллагааны бэрхшээлтэй.
- Нөхцөл байдлыг ойлгох чадвар сул.
- “Эрх дураараа”, “Зөрүүд” зангаас ялгаатай үйлдэл гаргадаг.

### Багшлах болон дэмжлэг үзүүлэх арга зүйн санал, зөвлөмж

Багшийн зүгээс анхаарах болон хийх зүйл	<ul style="list-style-type: none"><li>- Хүүхдийн байх газрыг тэмдэглэж өгөх.</li><li>- Хүлээх цагийг ойлгомжтой болгож, сандал зэргийг бэлдэж өгөх.</li><li>- Цонхон талын суудалд хүүхдийн анхаарал сарниулах зүйл их байдаг тул аль болох суулгахаас зайлхийх.</li><li>- Хүлээж чадсан, тэвчиж чадсан үед нь магтах.</li><li>- Хийх даалгаврыг тодорхой, хялбар үгээр тайлбарлах.</li><li>- Үйл ажиллагааг хэд хэдэн алхамд хувааж, тухайн алхам бүрт урамшуулж, дэмжлэг үзүүлэх.</li><li>- Даалгавар гүйцэтгэх хугацааг хэлж сэрүүлэг тавина.</li><li>- Багшийн асуултад хариулах дүрмийг урьдчилан тогтох /Гараа өргөсөн, нэрийг нь дуудсан тохиолдолд хариулна г.м/.</li><li>- Болно, болохгүйг ярилцаж тохирно. Зөрчвөл яах ёстой талаар хэлж өгнө.</li></ul>
Хүүхэдтэй ажиллах арга зүй	<ul style="list-style-type: none"><li>- Нэг даалгавар гүйцэтгэсний дараа амраах.</li><li>- Тогтвортой сууж чадахгүй болсон үед чимээ багатай газарт хэсэг амраах.</li><li>- Богино хугацаанд хийж дуусгах даалгавар өгч аажмаар хугацааг уртасгах.</li></ul>

**IV. ТУРШИЛТЫН СУРГУУЛИУД  
ДЭЭРХ ХҮҮХДИЙН ХЭРЭГЦЭЭНД  
НИЙЦҮҮЛЖ, ТОХИРОХ АРГА  
ЗҮЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭН  
АЖИЛЛАСАН ЖИШЭЭНҮҮД**



## ХҮҮХДЭД ИЛРЭХ БЭРХШЭЭЛ

### ① Сонсох

1. Анги	5 дугаар ангийн сурагч
2. Хэрэгжүүлэх хугацаа	2019-10~2019-04
3. Хүүхдийн онцлог, хичээл дээр тохиолддог бэрхшээл	<ul style="list-style-type: none"> <li>• Үсэг таньдаг боловч төсөөтэй үсгүүдийг хооронд нь хольж дууддаг. Жишээлбэл: С-Ш, Ц-З</li> <li>• Буруу бичдэг.</li> <li>• Зарим эгшгийг цэвэр дуудаж чаддаггүй. Жишээлбэл: Ө үсгийг хос эгшиг байдлаар дууддаг.</li> <li>• Хос эгшгийг цэвэр дуудаж чаддаггүй.</li> <li>• Үсэг буруу холбож бичдэг.</li> <li>• Дэвтрийн талбай хэтрүүлж бичдэг.</li> <li>• Уншиж чаддаггүй.</li> </ul>
4. Байж болох шалтгаан	<ul style="list-style-type: none"> <li>• Өгүүлэхүйн эрхтний бэрхшээл.</li> <li>• Авиа, үсэг буруу дууддаг.</li> <li>• Үсгийн зурлагууд буруу холболттой.</li> <li>• 2 үеийг хооронд нь холбож чаддаггүй.</li> <li>• Уншиж, бичиж чаддаггүй учраас монгол хэлний хичээлийг хийх сонирхолгүй.</li> </ul>
5. Тохируулгат орчин, тодорхой дэмжлэгийн агуулга	<p><u>Сургалтын агуулга, арга зүйн өөрчлөлт, тохируулга (хэрэглэгдэхүүн сонголт орно)</u></p> <ul style="list-style-type: none"> <li>• Асуулга бөглөж оношлох.</li> <li>• Тохирсон хэрэглэгдэхүүн сонгох.</li> <li>• Давхарлаж дуурайн бичих хэрэглэгдэхүүн сонгох.</li> <li>• Үе нүдлүүлэх зорилгоор үеийн хүснэгтийг ашиглах.</li> <li>• Үе бичүүлэх.</li> <li>• Дуудлага засах зорилгоор тухайн үсэг орсон 1 үетэй үг хэлүүлэх.</li> <li>• 1 үетэй үг цээжлүүлэх.</li> <li>• Жижиг эх хуулуулах.</li> <li>• Сонирхол болон хийж чаддаг зүйлд нь тулгуурлан хөгжүүлэхэд анхаарч ажиллах.</li> </ul> <p><u>Барилга байгууламжтай холбоотой өөрчлөлт, тохируулга</u> Тодорхой зүйл хийх шаардлагагүй.</p>

**Орчин тойрон (Ангийн хүүхдүүд, бусад багш нар, эцэг эх зэрэг)-той холбоотой авч хэрэгжүүлсэн арга хэмжээ**

- Багшийн урд ширээнд өөртэй нь ижил түвшний хүүхэдтэй суулгасан.
- Багштайгаа хамтарч ярилцах боломжийг олгож ажиллаж байна.
- Ангийн сурагчид хичээл хийхэд нь туслаж дэмждэг.
- Эцэг эхтэй нь байнга холбоотой байж ахицыг нь үнэлэх, урамшуулах, дэмжих, зөвлөгөө өгч хамтран ажиллаж байна.

**Бусад:** Бусад багш нартай хамтарч ажиллах.

**6. Хийгдсэн үйл ажиллагааны үр дүн, сайжруулах санал**



Хүүхдээ зөв оношилж тодорхойлсноор тохирох арга зүй, хэрэглэгдэхүүнээ сонгоход дөхөм болж байлаа.

УСГАЙ ХӨРГӨДӨТ БОЛОВСРОЙ ШААРДАГАТАЙ ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН АСУУГА		
2019.03	АГУУЛГА	С
<b>I. Сонгох</b>		
1	Амьдрал тогтворгүй эргэлтэнд өртөж чадна	3
2	Сонсох үйлдэл мэдрэлгүй тогтоож чадна	3
3	Томирлохын эсрэг хэлэ олох багш нь, дэлгэцэр, хэвэр огцрох ойгоос үргэлжлэж чадна	4
4	Ангилал зорилго байгаа үүргийг сайн ойлгож, хөгжсөж өргөтгөж	4
<b>II. Ярих</b>		
1	Ангийн хүүхдүүдийн туншад хэлэ гэлээс явуу үгийн сонгох	3
2	Хэл үгийг дуртайн ахиагүй бүтэн агуулгатай ярих	3
3	Ирмэл бичиг үгээр хэлбэлсэл гаргаж, өөрөөр туршица болон сонгох болсноо хэлж чадна	3
4	Үг сүлжээг хүүхдүүдтэй ярих өргөжсөж чадна	4
<b>III. Унших</b>		
1	Цаашан тогтоой үгсэг илгээгэр нь мэдэж (Ж. А. Усгийн харвал А гэж унших)	3
2	Цаашан тогтоой үгсэгийг дуудлагаг илгээгэр нь мэдэж (Ж. А. Усгийн харвал хэлэ чадна) (Амьт, дуудлагаг баруунааг тооноггүй)	4
3	Үргэлжлэж, Мэгийн төрийн үсэг өрсөн үг болон үгийг ахиагүй унших	2
4	Үсэг алгасан, тавьж унших зэрэг алдаа гаргалгүй чингэ дугаар тулалдгүй уншиха (Сүрэгт хүүхдийн тооноггүй)	2
5	Бичигдсэн, дармалас зөв унших чадна	2
<b>IV. Бичих</b>		
1	Цаашан тогтоой үсгийг сонсоход зөв бичих чадна	2
2	Үг, хэллэгийг сонсоход зөв бичих чадна	1
3	Үг, хэлэ мэтгэж, Мэгийн төрийн үсэг өрсөн үг болон үгийг сонсоход ахиагүй бичих	4
4	Ижил төстэй бичигдэлг үгүүдийг ахиураггүй зөв бичих чадна (Ж. илгээ, бичигдсэн том Б.У)	2
5	Үсэгүүдийг бичигдээр, дармалас зөв бичих чадна	2
<b>V. Тэм бичих</b>		
1	Хүрээ орооногдлууг 10 доор номж, хэсэг чадна	3
2	Ариг хүрээгүй номж, ариг бутаргаг хэлэх үйлдлийг ангийн хүүхдүүдтэй ярих түвшинд болох чадна	2
3	Ангийн хүүхдүүдтэй ижил түвшинд өгүүрбэргийг бичээж болох чадна	1

Хүүхдэд зориулсан		С
<b>VI. Нар хэлэхийг, өрсөн үг, хэвэр илгээгэр хэлэ болон хэлбэлсэлгэ болсноо</b>		
1	Ярихад ийм үгсэг болсон тухай илгээгэр, зөв ойлгож чадна	3
2	Ярихад, өрсөн үгсэг илгээгэр хэлэ болон хэлбэлсэлгэ болсноо хэлж үгсэг мэтгэж зөв ойлгож	4
3	Дүрээр, зөв хэлбэлсэлгэ ойлгож чадна	4
4	Цэг, харвал зөв хэлэ чадна, нар хэлэхийг хэлэ болон ойлгож	3
<b>VII. Бүтэн бичгийн мэдээлэл</b>		
1	Хэлэ болон, хэлэ тогтоох зэрэг гэр, хурууны үгүүрэг илгээгэр үйлдэлгэ болсноо хэлж чадна	3
2	Үсэг, бичгийг, мэдээллийг дугаар сайн бичих чадна	3
3	Дүр болон, бичгийг илгээгэр ангийн хүүхдүүдтэй ижил түвшинд хийж	3
4	Туршиг болон мэтгэж, дээр хийж, дэлгэцүүд ангийн хүүхдүүдтэй ижил түвшинд хийж чадна	2
<b>VIII. Хүрээг хариулах харилцаа</b>		
1	Зөв ойлгохыг цагвар болон хөгжсөлийг дараа найруулагдах тогтооно	3
2	Дүрээр баруунааг тогтоож чадна	4
3	Хариулах болон хүүхдүүдтэй санаа тавинаа хамтран үгсэг ажиллагаа хийж чадна	3
4	"Тур оч болгоно", "Баруунааг", "Уучлаарай" зэрэг үгийг зөв хэрэглэж чадна	3
<b>IX. Илгээгэр хэлэ</b>		
1	Баруунааг хурх төлөөгөө гаргана, хэвэр ачаагүй ч зүй өссөр нь үйлдэлгэ болно чадна	4
2	Сонирхолоо буруулаагүй, бичиг хийх зэрэг мэдээгөө хийхгүй асуулаад тооноггүй чадна	3
3	Мэргэж хэлэ алхыг гэрэлгэж зөв ярих, зөв тооногдож гаргаж ачаагүй зэрэг ярих тогтоож чадна	3
4	Өөрийн дурар хариуцаагүй ярихгүй, зөв хэвэр ярих, дуусгал сонсож чадна	4
5	Сүлжээг хариуцааг ачаагүй тайван байж үйлдэл хийж чадна	4
6	Бөөмөнхий үгсэгийг ярихад тогтооногдсон сүлжээ санааг хэлээр, өөрчлөх чадна	4
<b>НИЙТ</b>		
		<b>47.8</b>

Ижил үгийн хэлбэр дээр өөрчлөгдсөн амьдралыг ашиг төгсгөл байсан.  
 160/18  
 73.7/  
 Бичиг 20/18 - 40/  
 Чингэ 20/11 - 55/

Хүүхэд маань үсэг буруу холбож бичдэг учир зөв холбож бичүүлж сургах зорилгоор зурлагыг даган дуурайж бичүүлсэн.





### 1 үетэй үг нүдлүүлэх зурган хэрэглэгдэхүүний жишээ



### Жижиг эх уншиж байгаа нь



Жижиг эх:1

Амар

Амар суу. Амар ном сур. Амар ахаас асуу. Амар сүү ув.

Жижиг эх:2





Мөөг

Мөөг ойд ургав. Мөөгөөр хоол хийдэг. Мөөг амттай.  
Хүүхдийг хичээлдээ сонирхолтой идэвх оролцоотой байлгаж  
зорилгоор өөрийн хийж чаддаг болон сонирхолтой хичээл  
дээр нь тулгуурлан хөгжүүлэх болон сэдэлжүүлэх нэмэлт  
материалыг ашиглан ажилладаг.

Түүнчлэн урд ширээнд суулгаж багштайгаа ярилцах  
боломжийг олгож ажиллаж байна.

Тухайн хүүхэд маань тоо бодлого, хүн байгалийн хичээлд илүү сонирхолтой идэвхтэй оролцдог.

### Хүүхдийг идэвхжүүлэх нэмэлт хэрэглэгдэхүүний жишээ



7. Үр дүнг эргэн харж дүгнэсэн АУБ-ийн сэтгэгдэл

- ✓ Хүүхэд идэвхтэй болж байна.
- ✓ Монгол хэлний хичээлийг хийх сонирхолгүй, ном дэвтрээ орхиж ирдэг байсан бол хүүхдэд тохирсон арга зүй, хэрэглэгдэхүүнийг сонгон ганцаарчилж ажилласны үр дүнд үсгийн холболт зөв болж, өгсөн жижиг эхийг зөв хуулж бичдэг, нэг болон хоёр үетэй үгийг уншиж чаддаг болж байна.
- ✓ Ангийн сурагчид хичээл хийхэд нь тусалдаг.
- ✓ Ангийн сурагч, эцэг эхчүүдийн дунд ялгаварлан гадуурхалт байхгүй болсон.
- ✓ Ангийн сурагчидтайгаа байнга харилцдаг учраас, өөрийгөө илэрхийлэх чадвар сайжирсан.
- ✓ Цаашид 3 үетэй үгийг уншиж, 1-2 үетэй үгийг цээжээр бичиж чаддаг болгохыг хүсч байна.

## ХҮҮХДЭД ИЛРЭХ БЭРХШЭЭЛ

### ② Ярих

1. Анги	6 дугаар ангийн сурагч
2. Хэрэгжүүлэх хугацаа	2018.11-2019.04
3. Хүүхдийн онцлог, хичээл дээр тохиолддог бэрхшээл	<ul style="list-style-type: none"> <li>• Самбарт бичсэн зүйлийг хуулж бичихдээ алдаж бичдэг.</li> <li>• Цээж бичиг бичихдээ алдаж бичдэг.</li> <li>• Хуулж бичихдээ алдаж бичдэг.</li> <li>• Бичгийн хэв тааруу.</li> <li>• Эх зохиож бичихдээ үгээ алдаж бичдэг.</li> </ul>
4. Байж болох шалтгаан	<ul style="list-style-type: none"> <li>• Харааны чадвар сул.</li> <li>• Анхаарал тогтворгүй.</li> <li>• Сонссон зүйлээ үсгэнд буулгаж бичиж чаддаггүй.</li> </ul>
5. Тохируулгат орчин, тодорхой дэмжлэгийн агуулга	<ul style="list-style-type: none"> <li>• Ангийн урд эгнээнд суулгадаг.</li> <li>• Ойлгож туслах боломжтой хүүхдийн хажууд суулгана.</li> <li>• Эцэг эхтэй хамтран ажиллана.</li> <li>• Энэ хугацаанд үсгүүдийг нүдлүүлж, хуулж бичих даалгаврыг өдөрт бага багаар хийлгэж, үсэг хоорондын зөв холболтыг зааж, монгол хэлний эгшиг зохицох ёсыг зааж өгсөн.</li> <li>• Үгийг харандаагаар бичиж өгөөд хүүхдээр давхарлуулан бичүүлдэг, мөн өөрөө дэвтэр дээр нь бичиж өгөөд дуурайлган бичүүлж байсан.</li> <li>• Хүүхдийн дэвтэрт хуулж бичих хэсгийг цаасан дээр томоор хэвлэж өгч, бичүүлэхээс өмнө нэг удаа уншуулдаг.</li> <li>• Нэг ба хоёр үетэй үгсийг чанга дуудан цээжээр бичүүлдэг. Бичүүлэхээсээ өмнө үгсийг нэг удаа уншиж өгдөг.</li> <li>• Сурах бичгээр хангасан.</li> <li>• Зөв суулгаж бичүүлдэг.</li> </ul>
6. Хийгдсэн үйл ажиллагааны үр дүн, сайжруулах санал	<p><b>Үр дүн:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Нэг ба хоёр үетэй үгсийг цээжээр бичихдээ алдаа нь багассан.</li> <li>• Самбар дээрх бичвэрийг хуулж бичихдээ алдаа нь багассан.</li> <li>• Номноос хуулж бичихдээ алдаа нь багассан.</li> <li>• Хичээлийн цагаар зүгээр суухаа больсон.</li> <li>• Зөв сууж бичдэг болсон.</li> </ul> <p><b>Сайжруулах зүйл:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Бичгийн хэвийг сайжруулах.</li> <li>• Зөв бичгийн дүрмийг эхнээс нь тайлбарлаж заах.</li> <li>• Богино хэмжээний эхээр цээж бичиг хийлгэж сургах.</li> <li>• Хурдтай болгох.</li> </ul>



- Эх зохиож өөрөө бичдэг болгох.
- Гурав ба түүнээс дээш үетэй үгийг алдаагүй бичдэг болгох

Өмнө нь

Чадарбалын мэдэгдэл (1919-1920)  
Мөрсөн газар: Говь-Алтай аймгийн  
Лалшар сумын нутагт төрсөн.  
Ураан бүтээл "Алтай" >> Мунхал  
танчар >> рашаан. Малтай суруури-  
агсан >> түүгээр дугаар нүсрэг нэг гэж  
гэсэн би зэрэг олон арван шийдэг охион  
бичихэд гадна << Арван таван суруу >>  
Өөрийн зангаа >> << Ингэтэт болон  
дурьд суруул. Энэ сурууриг үн  
кото зогсонг туурвижээ.

Дараа нь

Мунхалтай сэтгэл  
Баларын монгол өгөө наймаг зэрэгс  
араагад нар нүдэн дээр суурийн (энд) шивээг  
илгээдэв. Би нарийг алгаар эхэн  
зөгсөгд шивээр тундур сурууриг  
завсаар алтан хараацай илгээгдэв.

Цээж бичиг


Өсөхөөс сурсан үндэсний хэл  
нарпаж балигуй сайн  
Угтэл орших төрөлх нутаг  
Салж балигуй орон.  
Ав овс о Д Нацагдорос

7. Үр дүнг эргэн харж дүгнэсэн АУБ-ийн сэтгэгдэл

Өнгөрсөн хугацаанд нэлээдгүй хугацаа өнгөрсөн ч монгол хэлээр алдаагүй бичүүлж сургахад амаргүй байв. Гэвч уг төслийн сургалтаас сонсож, мэдсэн арга туршлага дээрээ үндэслэн хичээж ажилласны үр дүнд сурагч маань өмнөхөөсөө бага ч болов ахиж байгаад баяртай байна. Сурагч маань номноосоо хуулж бичихдээ алдаа нь багассан, хичээлд идэвхтэй оролцож, самбарт байгаа зүйлийг хуулж чаддаг болж, хичээл хийх дур сонирхолтой болсон.

## ХҮҮХДЭД ИЛРЭХ БЭРХШЭЭЛ

### ② Ярих





1. Анги	7 дугаар ангийн сурагч.
2. Хэрэгжүүлэх хугацаа	2018-2019 оны хичээлийн жилийн 2, 3-р улирал.
3. Хүүхдийн онцлог, хичээл дээр тохиолддог бэрхшээл	Эмх цэгцгүй, их зүйл ярьдаг. Байнга гараа өргөж ярих гэж эрмэлздэг. Гэвч хичээлтэй холбогдолгүй зүйл ярьдаг.
4. Байж болох шалтгаан	Багшийн анхаарлыг байнга өөртөө татах гэж оролддог. / магадгүй энэ хүүхэд ганцаарддаг байж болзошгүй/ Ярих гэж байсан гол зүйлээ мартдаг.
5. Тохируулгат орчин, тодорхой дэмжлэгийн агуулга	<p><u>Сургалтын агуулга, арга зүйд оруулсан өөрчлөлт, тохируулга:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>• Багшид ойр, эхний эгнээнд суулгасан.</li> <li>• Ярих зүйлээ зөв цэгцтэй илэрхийлэхэд зааж сургасан Ганцаарчилсан уулзалт, ярилцлагыг 14 хоногт 1 удаа хийж ажилласан.</li> <li>• Хүүхдийн онцлогт тохируулсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.</li> </ul>
	
	<u>Барилга байгууламжтай холбоотой өөрчлөлт, тохируулга</u> Тодорхой зүйл хийгдээгүй байгаа.
	<p><u>Орчин тойронтой холбоотой авч хэрэгжүүлсэн арга хэмжээ :</u></p> <ul style="list-style-type: none"> <li>• Сайн найзыг нь хажууд нь суулгасан.</li> <li>• Зөв цэгцтэй ярихад дагуулан сургаж АУБ зөвлөгөө өгч ажилласан.</li> <li>• Хичээл заадаг багш нар ч мөн зөв цэгцтэй ярьж сурах тал дээр нь зааж зөвлөж байгаа.</li> </ul>



	<p><u>Бусад : эцэг эхтэй нь хамтран ажиллаж заавар зөвлөгөө өгөх.</u> Эцэг эхтэй нь уулзаж хүүхэдтэйгээ ярилцаж ойр дотно байх талаар зөвлөгөө өгсөн.</p>
6. Хийгдсэн үйл ажиллагааны үр дүн, сайжруулах санал	<p>Тус хүүхэдтэй ганцаарчлан зөвлөгөө өгч ажилласны үр дүнд сурагч нь өөрийгөө зөв цэгцтэй илэрхийлэх чадвар сайжирсан. Цаашид түүнийг мэргэжлийн сэтгэл зүйчтэй холбон зуучилж уулзуулах шаардлагатай санагдлаа.</p>
7. Үр дүнг эргэн харж дүгнэсэн АУБ-ийн сэтгэгдэл	<p>Миний бие болон хичээл заагч багш нар түүнд зөв цэгцтэй ярих, хувь хүн өөрийн хувийн нууцтай байх зэргийг зөвлөж байсан тул тэр юуг ярьж болох болохгүйгээ өөртөө дүгнэлт хийж бусадтай харилцдаг болсон.</p>




## ХҮҮХДЭД ИЛРЭХ БЭРХШЭЭЛ

### 2 Ярих

### 4 Бичих

1. Анги	9 дүгээр ангийн сурагч
2. Хэрэгжүүлэх хугацаа	II ба III улирал
3. Хүүхдийн онцлог, хичээл дээр тохиолддог бэрхшээл	<p><b>Ярих, бичих чадвар муу</b></p> <p>1. Эх болон урт өгүүлбэрийг уншаад утгыг ойлгодоггүй.</p> <ul style="list-style-type: none"> <li>Эхийг уншаад учир шалтгааныг тодруулах асуултад хариулахгүй.</li> <li>Эхийг уншаад эхийн үйл явдлыг өөрийн үгээр ярихгүй.</li> <li>Эхийг уншаад мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлэн бичихгүй.</li> <li>Эх зохион бичихдээ үг, өгүүлбэрийг зөв найруулдаггүй.</li> </ul> <p>2. Ойролцоо дуудлагатай утга өөр үгийг сольж бичдэг. Жишээлбэл:</p> <p><b>Олжээ – болжээ</b></p>  <p>3. Заавал байх ёстой үгийг орхиж бичдэг.</p> <p><b>Хүмүүсийн амьдралд машин ач холбогдолтой</b></p>  <p>4. Өгүүлбэр зохион найруулж бичихдээ өгүүлбэрийн нөхцөлийг буруу хэрэглэдэг, эсвэл орхиж бичдэг. Тиймээс утгын алдаа гарч зохиосон эх нь утга учиргүй болдог.</p>  
4. Байж болох шалтгаан	<p>Дараалал болон учир холбогдлыг гаргаж, өөрийн туршлага, санал бодлоо хэлж чаддаггүй, нэгтгэхдээ тааруу. Үгсийн, нөөц хомс Сурагчийн эцэг эх болон сурагч өөрөө сурах үйл явц хэвийн сайн гэж үздэг. Ээж нь манай хүүхэд маш их хичээдэг, даалгавар сайн хийдэг байхад яагаад дүн нь тааруу гарч байна гэж гайхдаг. Хэт их удаашралтай байдал ажиглагддаг.</p>

<p>5. Тохируулгат орчин, тодорхой дэмжлэгийн агуулга</p>	<p><u>Сургалтын агуулга, арга зүйн өөрчлөлт, тохируулга (хэрэглэгдэхүүн сонголт орно).</u></p> <ul style="list-style-type: none"> <li>• Ном сурах бичгээр бүрэн хангах.</li> <li>• Урд талын ширээнд сайн сурлагатан Э.О-тай хамт суулгах</li> <li>• Дасгал ажиллах заавар, тайлбарыг зөвхөн өөрт нь зориулан давтаж хэлэх.</li> <li>• Дахин дахин асуух, дахин дахин бичүүлэх.</li> <li>• Хэн? Ямар? Юуг ? Яав? гэх мэт асуултаар удирдаж өгүүлбэрийг зөв болгох аргыг хэрэглэлээ.</li> </ul> <table border="1" data-bbox="430 548 1072 651"> <tr> <td>Хэн?</td> <td>Ямар?</td> <td>Юуг ?</td> <td>Яав?</td> </tr> <tr> <td>Хүүхдүүд</td> <td>шинэ</td> <td>дууг</td> <td>сурав.</td> </tr> </table>	Хэн?	Ямар?	Юуг ?	Яав?	Хүүхдүүд	шинэ	дууг	сурав.
Хэн?	Ямар?	Юуг ?	Яав?						
Хүүхдүүд	шинэ	дууг	сурав.						
<p>6. Хийгдсэн үйл ажиллагааны үр дүн, сайжруулах санал</p>	<p><u>Барилга байгууламжтай холбоотой өөрчлөлт, тохируулга</u></p> <p><u>Орчин тойрон (Ангийн хүүхдүүд, бусад багш нар, эцэг эх зэрэг)-гэй холбоотой авч хэрэгжүүлсэн арга хэмжээ</u></p> <p>Ээж Ц- д өөрийн охин Б.Б-г бодитоор үнэлэх, хүүхдийнхээ суралцах байдлыг нь хүлээн зөвшөөрөхөд чиглэсэн зөвлөгөө өгнө.</p> <ul style="list-style-type: none"> <li>• “Үгсийн тайлбар толь” хөтлүүлнэ.</li> </ul> <p>Үүнд: А. 2-р улиралд өдөрт 1 шинэ үг Б. 3-р улиралд өдөрт 2 шинэ үг</p>  <p>• Бусад Хичээлийн дараа өдөр бүр 20 минут орчим АУБ-тай хамт богино эхийг уншсаны дараа утгыг ойлгосон эсэхийг шалгана.</p> <p>Эх, өгүүлбэр зохиоходоо үг орхигдуулах, үгийн нөхцөл орхиж гээж бичих алдаа нь багассан. Тухайлбал: “Машин” сэдэвт эхийг зохиосон нь:</p> 								



	<p style="text-align: center;"><b>ХҮҮХЭДТЭЙ АЖИЛЛАСАН БАЙДАЛ</b></p> <div style="display: flex; justify-content: space-around;"> <div style="text-align: center;"> <p>ГАНЦААРЧЛАН АЖИЛЛАХААС ӨМНӨ \12 САРД\</p>  </div> <div style="text-align: center;"> <p>ГАНЦААРЧЛАН АЖИЛЛАСНЫ ДАРАА \3 САРД\</p>  </div> </div>
<p>7. Үр дүнг эргэн харж дүгнэсэн АУБ-ийн сэтгэгдэл</p>	<div style="display: flex;"> <div style="flex: 1;">  </div> <div style="flex: 2;"> <p>Ангийн сурагч Б.Б-ийн зохион найруулж бичих чадварыг сайжруулахад анхаарч ажиллалаа. 9-р ангийн монгол хэл бичгийн улсын шалгалтын жишиг даалгавар нь “Онгоц” эхийг уншиж ойлгоод, ойлгосны дагуу “Машин” сэдэвт эх зохиох байлаа. Энэ ажилд тулгуурлан дээрх эхийг 4-5 удаа найруулан бичүүлж засан сайжруулав. Мөн “Эрүүл мэнд”, монгол бичиг, англи хэл, математик, түүх нийгмийн ухааны хичээл ордог багш нартай уулзаж хамтран ажиллав. Сурагчийн найруулан бичих чадвар сайжирч байна. Хамгийн чухал нь өөрийн алдааг ухамсарлаж чаддаг болсон байна.</p> </div> </div>

## ХҮҮХДЭД ИЛРЭХ БЭРХШЭЭЛ


### 2 Ярих

### 4 Бичих

1. Анги	5 дугаар ангийн сурагч
2. Хэрэгжүүлэх хугацаа	2018.12-2019.03
3. Хүүхдийн онцлог, хичээл дээр тохиолддог бэрхшээл	<ul style="list-style-type: none"> <li>• Хичээл дээр тогтож сууж чаддаггүй.</li> <li>• Хэлний угийн “Н” үзүүрийн “Н” ялгадаггүй.</li> <li>• Хүнтэй ярихдаа сандруу бөөрөнхий хэлтэй юм шиг ойлгомжгүй сонсогддог.</li> <li>• Үе тэнгийн хүүхдүүдтэй яриа өрнүүлж чаддаггүй.</li> <li>• Самбарт бичсэн үгсийг хараад хуулж бичиж чаддаггүй.</li> <li>• Цээж бичиг бичихдээ маш их алддаг.</li> <li>• Энгийн нэмэх болон хасах тоог бодож чаддаггүй.</li> </ul>
4. Байж болох шалтгаан	<ul style="list-style-type: none"> <li>• Анхаарал төвлөрөл муу.</li> <li>• Хүлээж авах, ялгах чадвар сул.</li> <li>• Өөртөө итгэх итгэлгүй.</li> <li>• Хэлний угийн “Н” үзүүрийн “Н” ялгаж хэлж чаддаггүйгээс бөөрөнхий хэлтэй мэт сонсогддог.</li> <li>• Хэлэх гэж буй санаагаа нэгтгэн илэрхийлэх чадвар сул.</li> <li>• Хуулж бичих хэсгийг аль болохыг ойлгодоггүй.</li> <li>• Сонссон зүйлээ бичиж чаддаггүй.</li> </ul>
5. Тохируулгат орчин, тодорхой дэмжлэгийн агуулга	<p><u>Сургалтын агуулга, арга зүйн өөрчлөлт, тохируулга (хэрэглэгдэхүүн сонголт орно).</u></p> <ul style="list-style-type: none"> <li>• 7 хоногт 6 цагийн хичээлийг 1, 3, 5 дахь өдрүүдэд ганцаарчилсан хэлбэрээр заадаг.</li> <li>• Хэлний угийн “Н” үзүүрийн “Н” орсон нэг, хоёр үетэй үгнүүдийг байнга давтан хэлүүлж, уншуулж, бичүүлдэг. /хана, унь, тана, тун, сан, ганган, лувсан, хонь, байшин г.м /</li> <li>• Хэлний угийн “Н” үзүүрийн “Н” орсон үгсээ ашиглан түргэн хэллэг, богино өгүүлбэр болгон ярилцдаг.</li> <li>• Өөрийнх нь дуртай зурган карт, шоо, бөмбөг ашиглан хамтдаа тоглонгоо богино өгүүлбэрээр ярилцдаг.</li> <li>• Зөв хэлж, бичих бүрт нь өөрт нь болон анги хамт олон нь сайжирч байгааг нь хэлж сайшаадаг.</li> <li>• Самбараас хуулж бичих хэсгийг тодруулан тэмдэглэж өгдөг, эсвэл томоор цаасан дээр хэвлэн урд нь тавьж өгдөг.</li> <li>• Алдсан үгсийг дууриалган бичүүлж, мөн өөрөөр нь чанга хэлүүлж бичүүлдэг.</li> <li>• Тоо бодохдоо санасан тоог нь тусад нь бичүүлдэг.</li> </ul>

	<p><u>Барилга байгууламжтай холбоотой өөрчлөлт, тохируулга</u>  <i>Тусгайлан кабинет тохижуулж, хэрэглэгдэхүүн бэлдсэн./жижиг ширээ сандал, номын тавиур, зураг үгтэй картууд, үлгэрийн ном.../ Хичээлийн 4 байрны гадна талд налуу зам хийсэн</i></p> <p><u>Орчин тойрон (Ангийн хүүхдүүд, бусад багш нар, эцэг эх зэрэг)-той холбоотой авч хэрэгжүүлсэн арга хэмжээ</u></p> <ul style="list-style-type: none"> <li>• Ангийн хүүхдүүдэд нь найз болж хичээлээ хамт хийж, ярилцаж байхыг зөвлөдөг.</li> <li>• Ээж аавтай нь 7 хоногийн 5 дахь өдөр болгон уулзаж бичиж сурсан, хэлж сурсан үг, өгүүлбэрийг нь бичиж өгч явуулж гэрт нь давтуулахыг зөвлөдөг.</li> <li>• Биеийн тамирын багш нь дасгал маш сайн хийдэг гэж магтдаг болсон.</li> </ul> <p><u>Бусад</u></p> <ul style="list-style-type: none"> <li>• Өдөрт хүүхдэдээ 5 минут зарцуулж өнөөдөр юу сурсан талаар заавал асууж байхыг эцэг эхэд зөвлөдөг.</li> </ul>
<p>6. Хийгдсэн үйл ажиллагааны үр дүн гарсан сайжруулах санаа</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Өөрийгөө сайжирч байгаа гэж сонсох бүрт баярладаг.</li> <li>• Өдөр бүр хичээллэж болох уу, багш аа гэж асуудаг болсон.</li> <li>• Нэг үгтэй хэлний үзүүрийн “Н” болон хэлний угийн “Н”-ыг маш чангаар уншиж, хэлж ялгааг нь гаргадаг болсон.</li> <li>• Нэмэх, хасах үйлдлийн тоог шууд боддог болсон.</li> </ul> <div style="display: flex; justify-content: space-around;">   </div> <ul style="list-style-type: none"> <li>• Хичээлийн явцад амрааж шоо хаяж, хүрд эргүүлж тоглонгоо асуулт асууж ярилцах их дуртай болсон.</li> <li>• Түргэн хэллэг цэвэрхэн хэлдэг болсон. /Намрын цас хайрна, Хаврын цас хална. Шаврыг усаар зуурна, Саврыг хусаар зорно/</li> <li>• Элементийн дэвтэр дээр зөвхөн тодруулсан хэсгийг самбараас хуулж гаргацтай бичдэг болсон.</li> <li>• Цээжээр бичихдээ чангаар давтан хэлж өөрийгөө сонсож бичсэнээр алдаа нь багасаж байгаа.</li> </ul>







- Манай ангийн хамгийн сайн хүүхдүүдтэй адилхан багш намайг магтаад байгаа юм чинь би ангийн дарга ч болж болох юм байна гэж хэлж байгаа.
- Манай ангийн хүүхдүүд надтай ярьдаг болсон, би нэг л найзтай байсан одоо маш олон найзтай болсон гэж багшдаа хэлдэг.



- Бичгийн хэв маш их сайжирсан.



<p>7. Үр дүнг эргэн харж дүгнэсэн АУБ-ийн сэтгэгдэл</p>	<p>Анх хичээллэж эхлэхээс өмнө хичээлдээ орж ирээд л тарах хүртэл чимээгүй сууж байгаад л тараад явдаг мөн багш юм асуувал хариулдаг хүүхэд байсан. Ээж, аав нь ирж уулздаггүй холбоо барьдаггүй, жилдээ 1, 2 удаа л хуралд ирдэг, эцэг эхийн анхаарал халамж сул.</p> <p>Энэхүү төсөл хэрэгжиж эхлээд анги удирдсан багшийн зүгээс төсөлд хамрагдахыг аав ээж болон өөрт нь зөвлөсний үндсэн дээр орсон. Төсөлд хамрагдах хугацаандаа манай хүүхдэд маш их өөрчлөлт орсон. Жишээлбэл:</p> <ul style="list-style-type: none"><li>- Өөрийгөө бусад хүүхэдтэй адилхан гэсэн ойлголттой болж хичээлдээ ирэхдээ ойр хавьд байдаг найзуудтайгаа хамт ирдэг болсон.</li><li>- Хичээл дээрээ ангийнхантайгаа яриа өрнүүлж их завсарлагаанаар хамт гарч завсарладаг болсон.</li><li>- Өөрийг нь магтахаар илүү их хичээдэг.</li><li>- Аав ээж нь 7 хоног бүр боломж гарвал ирж уулзах, эсвэл утсаар холбогддог болсон.</li><li>- Хичээлдээ эрс сайжирч: алдаагүй, цэвэрхэн бичдэг болсон</li><li>- Хэл ярианаасаа санаа зовохгүйгээр ярьдаг болсон гэх мэт маш их сайн үр дүн гарсан.</li></ul> <p>Манай сургууль дээр төсөл хэрэгжүүлсэн танай төслийн баг хамт олонд маш их баярлаж байгаагаа үүгээр уламжлахдаа таатай байна.</p>
---	--

## ХҮҮХДЭД ИЛРЭХ БЭРХШЭЭЛ

### ② Ярих

### ③ Бичих


1. Анги	3 дугаар ангийн сурагч
2. Хэрэгжүүлэх хугацаа	2018 оны 10-р сараас 2019.03-р сар хүртэл
3. Хүүхдийн онцлог, хичээл дээр тохиолддог бэрхшээл	<ul style="list-style-type: none"> <li>• Бүх үсгээ таньдаг, авиа зөв дууддаг ч үе бүтээж чаддаггүй.</li> <li>• Үгийн дунд буй урт эгшгийг богино эгшгээр уншдаг.</li> <li>• Үсэг сольж хэлдэг. Тааж уншдаг.</li> <li>• Нэг дор олон өгүүлбэрээр яривал бүрэн ойлгодоггүй. Зарим зүйлийг нь мартдаг.</li> <li>• Бүтэн өгүүлбэрээр ярьдаггүй нэг нэгээр үгээ зөөж ярьдаг. Үгсийн сан цөөн.</li> <li>• Өөртөө итгэлгүй.</li> <li>• Дармалаас бичмэл рүү хөрвүүлэн бичдэг ч үсэг орхих, үсэг солих гэх мэт алдаатай бичдэг.</li> <li>• Үсгийг хооронд нь буруу холбодог учир удаан бичдэг, бичгийн хэв ойлгомжгүй.</li> <li>• Цээжээр бичиж огт чаддаггүй.</li> <li>• Гэр бүлийн харилцааны сөрөг нөлөө ихтэй, буруу дадал хэвшилтэй.</li> <li>• Бие даан сурах арга барил эзэмшээгүй учир багшийн дэмжлэгтэй, шахаж шаардуулж хичээл хийдэг.</li> </ul>
4. Байж болох шалтгаан	<ul style="list-style-type: none"> <li>• Үелж уншиж сураагүй учир хоёр үсэг нийлээд хэрхэн уншдаг талаар мэдэхгүй, үе цээжлээгүй, үеэр уншиж чаддаггүй.</li> <li>• Үгийн дунд урт эгшиг гэж таньдаг ч урт эгшгээр дуудан уншихаа мартдаг.</li> <li>• Анхаарал төвлөрөөгүй, дутуу ажигласнаас үсэг сольдог.</li> <li>• Хүмүүстэй бага харилцдаг, ном уншдаггүйгээс цөөн үгээр ярьдаг.</li> <li>• Анхаарлаа төвлөрүүлж чадахгүй, идэвхгүй сонссоноос ойлгодоггүй.</li> <li>• Үгийн баялаг цөөн учир санаа бодлоо ямар үгээр илэрхийлэхээ мэддэггүй.</li> <li>• Уншиж чаддаггүй үсэг үсгээр нь харж хуулдаг учир үсэг орхидог, сольдог.</li> <li>• Үеэлж уншиж сураагүй учир хоёр үсэг нийлээд хэрхэн дуудагддаг талаар мэдэхгүй учир аль тод сонсогдож байгаа үсгийг бичдэг.</li> <li>• Амьдралын чанар, зөв зохистой хооллодоггүй учир хичээл дээр толгой өвдөх, дотор муухайрах, гэдэс өвдөх гэх мэт биед таагүй байдал нь суралцахуйн хоцрогдол үүсэхэд нөлөөлсөн.</li> <li>• Сурагч өөрөө болон эцэг эх нь хичээл таслуулдаг. (дүү нарыг нь харуулдаг, түлээ нүүрсэнд явуулдаг)</li> </ul>

5. Тохируулгат  
 орчин, тодорхой  
 дэмжлэгийн  
 агуулга



Сургалтын агуулга, арга зүйн өөрчлөлт, тохируулга (хэрэглэгдэхүүн сонголт орно)

- Тоглох сонирхолтой учир гийгүүлэгч үсгүүдийг эгшиг үсэгтэй холбож үе бүтээлгэж уншуулдаг. Үе цээжлүүлдэг.



- Үе үеэр нь заагласан буюу өнгөөр ялгасан нэг ба хоёр үетэй үг уншуулдаг.
- Дугуй унах дуртай тул түүнтэй холбогдолтой төрөл бүрийн эх уншуулдаг. Утгыг нь яриулж байна.

- Урт эгшгийг нь тодруулсан үг уншуулсан.
- Том бичвэртэй богино өгүүлбэртэй эх уншуулдаг.
- Хялбар, жижиг эх уншуулдаг.



- Ертөнцийн гурав уншуулдаг. Цээжлүүлдэг учир нь нэг үг олон удаа орсон байдаг учир үг нүдэлдэг, цээжилэхэд амархан байдаг.
- Багштайгаа хамтраад сурагчдаас авсан цээж бичгийн шалгалт засдаг. Дэвтэр зассанаар үг тогтоох, унших чадвар нь ахисан. Анх засаж эхлэхдээ



удаан байсан бол одоо хурдан зөв засдаг болсон мөн өөрийгөө багш гэж баярлаж урам авдаг болсон.





- Комик ном, богино хэмжээтэй үлгэр уншуулдаг.
- Гарын жижиг булчин хөгжүүлэх зорилгоор эв долоо эвлүүлэх, puzzle эвлүүлэх, шагайгаар наадах гэх мэт тоглоомын аргуудыг ашигладаг.
- Элементээр бичсэн эх тодруулан бичүүлдэг. Бичих явцдаа уншдаг.
- Бичмэл эхийг цэвэр нямбай хуулан бичүүлсэн.
- Гэрийн даалгаварт 4-5 үгнээс бүтсэн өгүүлбэр уншаад, нүдлээд ирээрэй гэж

өгдөг маргааш нь цээж бичиг авдаг энэ арга их үр дүнтэй байв.

- 1-р ангийн үсэг үзэж байгаа сурагчдыг уншуулах үүрэг даалгавар өгснөөр сурагчийн унших хурд ахисан. Унших сонирхолтой болсон.



- Сурагчийн унших, бичих чадварууд ахих бүрт тохирсон урмын үг хэлдэг.



2018.11.05 Сурагчийн бичгийн хэв ойлгомжгүй, алдаатай бичдэг байсан .

2019.03.06 Хуулан бичихдээ алддаггүй, бичгийн хэв ойлгомжтой элементээр бичдэг.

Орчин тойрон (Ангийн хүүхдүүд, бусад багш нар, эцэг эх зэрэг)-той холбоотой авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

- Дугуй унах дуртай учир унадаг дугуй орсон эх уншуулдаг. Утгыг нь яриулдаг.
- Ээжтэй нь уулзаж тухайн хүүхдийн ахицын талаар ярьж, цаашид ямар ямар боломжууд байгаа талаар ярилцсан.
- Эцэг эхэд нь тухайн хүүхэдтэй ажиллах зөвлөгөө өгсөн.
- Эцэг эхтэй нь харилцах дэвтэр гаргаж гэрийн даалгавар, хэрхэн гүйцэтгэх талаар зөвлөгөө бичдэг.
- Өөрийн хийх дуртай зүйл, сонирхол, тоглоом дээр нь тулгуурлан хичээл хийлгэх зөвлөгөө өгсөн.
- Сурагчийн суух суудлыг нь ойр ойрхон сольж, үлгэр жишээ сурагчдын болон багшийн хажууд сэлгэн суулгадаг.





<p>6. Хийгдсэн үйл ажиллагааны үр дүн, сайжруулах санал</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Сурагчийн ойрын зорилго: Үе бүтээж, үе унших, цээжлэх, үе цээжээр бичих, алдаагүй элементээр хуулан бичиж сурах богино хугацааны зорилгодоо хүрсэн.</li> <li>• Сурагчийн урт хугацааны зорилго: Унших, цээжээр бичих, бие даан суралцах чадвартай болох, уншсан зүйлийнхээ утгыг бүтэн өгүүлбэрээр ярьдаг болох зорилготой. Үүнээс минутанд 10-15 үг уншдаг болсон. Уншсан зүйлийнхээ талаар бүтэн өгүүлбэрээр ярьдаг. Харин цээжээр бичих, бие даан суралцах арга барил эзэмшээгүй байна.</li> <li>• Өөртөө уншиж чадна гэсэн итгэлтэй болсон.</li> <li>• Хичээл тасалдаггүй. Хоцорсон ч гэсэн хичээлдээ ирдэг болсон.</li> <li>• Багшид дэмжлэг үзүүлж, бүх зүйлд туслах идэвхи, сэтгэлтэй болсон.</li> </ul>
<p>7. Үр дүнг эргэн харж дүгнэсэн АУБ-ийн сэтгэгдэл</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Тухайн сурагчийг илүү судлах, ажиглах, хоцрогдоод байгаа шалтгааныг нь илрүүлэх хэрэгтэй.</li> <li>• Сурагчийн эцэг эхийг сургалтын үйл ажиллагаан татан оролцуулах, арга зүйн зөвлөгөө өгөх, хоцрогдлыг арилгах ГСТ-г хамтран боловсруулах.</li> <li>• Тухайн сурагчийг бусад сурагчтай харьцуулахгүй байх, ахиц амжилтыг нь үнэлэх хэрэгтэй.</li> <li>• Суралцахуйн хоцрогдолтой, сурагчидтай ажиллаж байгаа багш нар тухайн хүүхдэд тохирсон хэрэглэгдэхүүн, гарын авлага, сургалтын материалыг бэлтгэх шаардлагатай байна.</li> <li>• Тухайн сурагчийн дуртай, сонирхолтой зүйлд нь тулгуурлан арга зүйг сонгон хичээллэх.</li> <li>• Сурагчид гүйцэтгэж буй зүйлд нь тохирсон урам өгөх</li> <li>• Сурагчтай илүү цаг гарган ажиллах.</li> <li>• Ангийн сурагчдад нь зөвөөр ойлгуулах, сурагчид туслах, дэмжих үйлийг хамтдаа гүйцэтгэж байх.</li> <li>• Сурагчийг хичээлээс гадуур дугуйланд явуулж авъяасыг нь хөгжүүлэх, нийгмийн идэвхийг нь нэмэгдүүлснээр бие даан суралцах чадвартай болдог.</li> <li>• Сурагчид тохирсон гэрийн даалгавар өгөх.</li> </ul>

## ХҮҮХДЭД ИЛРЭХ БЭРХШЭЭЛ

### 3 Унших

### 4 Бичих




1. Анги	2 дугаар ангийн сурагч
2. Хэрэгжүүлэх хугацаа	2, 3 -р улиралд
3. Хүүхдийн онцлог, хичээл дээр тохиолддог бэрхшээл	<p>Хуулж бичихдээ алддаг. Цээжээр бичиж чаддаггүй. Үсэг алгасах, гааж унших зэрэг алдаа гаргадаг. Цээжээр бичихдээ урт хос эгшиг, зарим гийгүүлэгч үсгийг бичихдээ алддаг. Хүүхдийн хувьд биеийн эрүүл мэнд сайн, ухаан санаа хэвийн боловч хичээл дээр анхаарал нь төвлөрдөггүй. Зан аашийн хувьд тогтворгүй. Бие даан хийх чадвар сул. Сурлагаараа үеийн нөхдөөсөө хоцорсон.</p>
4. Байж болох шалтгаан	<ul style="list-style-type: none"> <li>• Үсгийн хэлбэрийг цээжилж ойлгож чаддаггүй.</li> <li>• Сонссон зүйлээ үгээр илэрхийлж буулгаж чаддаггүй.</li> <li>• Нүдээрээ гүйлгэж уншиж чаддаггүй.</li> <li>• Анхаарлаа өөр юманд хандуулдаг, үгийн утгыг ойлгох зэрэгт төвлөрүүлж чаддаггүй.</li> </ul> <p><u>Сургалтын агуулга, арга зүйн өөрчлөлт, тохируулга (хэрэглэгдэхүүний сонголт орно).</u></p> <p>-Хүүхдийн анхаарлын төвлөрөлт муу амархан сарнидаг байдлыг харгалзан хамгийн урд ширээнд суулгасан. -Хүүхэдтэй хэрхэн ажиллах талаар багаараа хамтран төлөвлөгөө гаргаж ажилласан. -Гэрийн даалгаврыг тусад нь бэлдэж өгдөг болсон. -Багш арга зүйдээ шинэчлэл хийсэн.</p>
5. Тохируулгат орчин, тодорхой дэмжлэгийн агуулга	<p><i>Үгийг үе, үеэр нь өнгөөр ялгаж өгсөн. Энэ даалгаврыг ижил түвшний хүүхдүүдэд бас өгч байлаа.</i></p> <div style="display: flex; justify-content: space-around;"> <div data-bbox="369 1412 561 1557"> <p><b>Төл мал</b> Хурга, ишиг, унага, тугал, болгыг төл мал гэнэ. Хавар төл мал төллөнө. Мал төллөхөд хүүхэд тусална. Төлөөр мал өснө. Төл бүрийг мал болгохын төлөө хүн бүр мэрий. Тарсан мал тал бүрийн ашигтай.</p> </div> <div data-bbox="571 1412 763 1557"> <p><b>Бороо</b> Ширүүн бороо орлоо. Болд, Сүхээ, Наран нар бороонд нерсон. Аадар борооноос бид эрхэн. Борооны далаат унар их сайхан. Бурмаа борооноос их аллаа. Салги салгиан ширүүн бороо орсон. Хумуус бороо ороход үнээ савсан. Нараа бамбаруушар наадав. Хүүхдэд бороо ороход бая баригдаа.</p> </div> <div data-bbox="772 1412 964 1557"> <p><b>Аууцгаа</b> Хүүхдэд номын сан үнсүүлэв. Бадмаа, Бурмаа, Балдан 3 бамбаруш эрсэн. Би Бүрээ үлээлээ. Балдан, Болд нар бая баригдаа. Болд бөхийн мэх султла. Болд бөхийн мэхээр уран баригдан шийсэн. Хүүхдэд буран идсэн.</p> </div> <div data-bbox="974 1412 1166 1557"> <p><b>Тоо бодол</b> Тоо бодол толгой саргадаг хэвхэн багш байнга хэлдэг. Багш бичдээр байнаа тоо бодуулдаг. Тав дээр хэлт нэмэлт алаа гаргах вэ. Арваас хэсгийг хасвал тг гаргах вэ? Гэх мэт өдөр бүр тоо бодлоо агуулдаг. Танираа, Тунгалаг, Төмөр гурав тоомдоо хамгийн сайн хүүхдүүд.</p> </div> </div> <div style="display: flex; justify-content: space-around; margin-top: 10px;"> <div data-bbox="369 1580 577 1715"> <p><b>Урц</b> 1. Эзнийг ойлгон сайн уншижарай. 2. Эзнийг үеэр тасалж бичижарай 3. Эзэс эр, ан үг тус бүр 3-г түгж бичижарай.</p> <p><b>Цаатан араудад тайлал нутагт цаатан хүүхдүүс туршид амьдарч...</b> Урцыг нарийн лавуу болго өмсөөр барьцга. Цаатанууд цаа булгыг уншаарай ашигтай. Машин хүснэгдээр хэрэглэдэг.</p> </div> <div data-bbox="584 1580 887 1715"> <p><b>наадан</b> Хүмүүс наадмаар хурдан морио уралдуулав. Миний өвөө 2 шүдлэн сойсон. Ах дүү 2, шүдлэн унаад наадамд уралдав. Ахын унасан шүдлэн айрагдав. -Хэн хэн хурдан шүдлэн унав.</p> </div> </div>

	<p style="text-align: center;"><i>Хүндэвтэр үгсийг тодруулж өгсөн</i></p> <div style="text-align: center;">  </div> <p style="text-align: center;"><i>Даган дуурайж бичих эх бэлтгэж өгсөн</i></p> <div style="display: flex; justify-content: space-around;"> <div style="text-align: center;">  </div> <div style="text-align: center;">  </div> <div style="text-align: center;">  </div> </div> <p><u>Барилга байгууламжтай холбоотой өөрчлөлт, тохируулга</u></p> <p><u>Орчин тойрон (Ангийн хүүхдүүд, бусад багш нар, эцэг эх зэрэг)-той холбоотой авч хэрэгжүүлсэн арга хэмжээ</u></p> <ul style="list-style-type: none"> <li>• Эцэг эхтэй нь тодорхой хэмжээнд хамтран ажилласан, зөвлөгөө өгч байсан</li> </ul>																								
<p>6. Хийгдсэн үйл ажиллагааны үр дүн, сайжруулах санал</p>	<p>Бусад:</p> <p><b>Багаар хийх ажлын төлөвлөгөө:</b></p> <table border="1" data-bbox="376 1066 1155 1437"> <thead> <tr> <th>№</th> <th>Хийх ажил</th> <th>Хугацаа</th> <th>Хариуцах эзэн</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Хүүхдийн түвшинд тохирсон даалгавар бэлдэх</td> <td>1сарын 14</td> <td>Багийн гишүүд</td> </tr> <tr> <td>2</td> <td>Богино эх уншуулах, яриулах</td> <td>1,3 дахь өдөр</td> <td>Дэжидмаа, Буянхишиг</td> </tr> <tr> <td>3</td> <td>Цээж бичиг хийлгэх</td> <td>1,3дахь өдөр</td> <td>Дэжидмаа</td> </tr> <tr> <td>4</td> <td>Минутын уншлага хийлгэх</td> <td>2,4 дэх өдөр</td> <td>Тэрбишдулам, Түмэнжаргал</td> </tr> <tr> <td>5</td> <td>Эцэг эхэд нь зөвлөгөө өгч хамтран ажиллах</td> <td>Өдөр бүр</td> <td>АУБ – Дэжидмаа</td> </tr> </tbody> </table>	№	Хийх ажил	Хугацаа	Хариуцах эзэн	1	Хүүхдийн түвшинд тохирсон даалгавар бэлдэх	1сарын 14	Багийн гишүүд	2	Богино эх уншуулах, яриулах	1,3 дахь өдөр	Дэжидмаа, Буянхишиг	3	Цээж бичиг хийлгэх	1,3дахь өдөр	Дэжидмаа	4	Минутын уншлага хийлгэх	2,4 дэх өдөр	Тэрбишдулам, Түмэнжаргал	5	Эцэг эхэд нь зөвлөгөө өгч хамтран ажиллах	Өдөр бүр	АУБ – Дэжидмаа
№	Хийх ажил	Хугацаа	Хариуцах эзэн																						
1	Хүүхдийн түвшинд тохирсон даалгавар бэлдэх	1сарын 14	Багийн гишүүд																						
2	Богино эх уншуулах, яриулах	1,3 дахь өдөр	Дэжидмаа, Буянхишиг																						
3	Цээж бичиг хийлгэх	1,3дахь өдөр	Дэжидмаа																						
4	Минутын уншлага хийлгэх	2,4 дэх өдөр	Тэрбишдулам, Түмэнжаргал																						
5	Эцэг эхэд нь зөвлөгөө өгч хамтран ажиллах	Өдөр бүр	АУБ – Дэжидмаа																						



Ажиллахын өмнө	Ажилласны дараа
1 минутанд 10 – 18 үг уншдаг. Үеэ мэдэх боловч уншихдаа удаан.	30-аас дээш үг уншдаг болсон
Цээжээр бичихдээ урт хос эгшиг, зарим гийгүүлэгчийг алдаж бичдэг.	Цээж бичиг хийлгэхэд алдааны тоо багассан.
Самбараас хуулж бичихдээ алддаг.	Хуулан бичихдээ бараг алдахаа больсон. Бичгийн хэв эрс сайжирсан.
Анхаарал нь төвлөрдөггүй, зан аашийн хувьд тогтворгүй	Ярих чадвар сайжирсан .
Сурлагаараа үеийн нөхдөөсөө хоцорсон.	Би чадна, сурна, гэсэн итгэлтэй болсон.






	
<p>Өөрийнх нь түвшинд тохирсон даалгавар тусгайлан бэлдэж өгөх шаардлагатай.</p>	
	<p>Хичээлийн дараа ганцаарчлан ажиллах нь үр дүнтэй байв.</p>



<p>7. Үр дүнг эргэн харж дүгнэсэн АУБ- ийн сэтгэгдэл</p>	<p>Сонгогдсон хүүхэд маань богино хугацаанд ахиж байгаад баяртай байна.</p> <p>Тухайн хүүхдийн зан чанар, хөгжил төлөвшил, ахуй нөхцөл, эцэг эхийн боловсрол зэргийг сайн судалж, багш аргаа зөв сонгож, тохируулгыг хийж чадвал тодорхой хэмжээгээр ахиц гардаг юм байна гэдгийг мэдэж авсан.</p> <p>Багаар хамтран ажилласан тул богино хугацаанд үр дүн гарсан гэж бодож байна.</p> <p>Нэг баг болж ажилласан багш нартаа маш их баярлалаа.</p> <p>“Б” гэдэг сурагч маань өөрөө их идэвхтэй байж өдөр тутмын даалгавраа маш сайн хийж байсанд багшийн зүгээс талархалтай байна. Энэ төсөл манай сургууль дээр амжилттай хэрэгжснээр хүүхдүүд өөр өөрийнхөө түвшинд ахиж, багш нар хамтран ажилласнаар шинэ зүйл сурч арга зүй нь улам баяжигдсан гэдэгт би итгэлтэй байна.</p>
--	---

## ХҮҮХДЭД ИЛРЭХ БЭРХШЭЭЛ

### ④ Бичих

1. Анги	4 дүгээр ангийн сурагч
2. Хэрэгжүүлэх хугацаа	2018.9-2019.03
3. Хүүхдийн онцлог, хичээл дээр тохиолддог бэрхшээл	<ul style="list-style-type: none"> <li>• Самбарт бичсэн зүйлийг муу хардаг.</li> <li>• Чээжээр бичиж чаддаггүй.</li> <li>• Өнгө ялгадаггүй.</li> <li>• Үгийг үеэр тасалж чаддаггүй.</li> <li>• 2, 5 хүрдээ мэддэг бусад хүрд мэдэхгүй.</li> </ul>
4. Байж болох шалтгаан	<ul style="list-style-type: none"> <li>• Сул хараатай учир бүх хичээлээсээ хоцорсон.</li> <li>• Казак хүүхэд учир монголоор ярих болон бичихдээ муу</li> <li>• Сул хараатай учир өнгө ялгадаггүй.</li> <li>• Үсгээ мэддэг ч үг бүтээхдээ буруу бичдэг.</li> <li>• Учир шалтгааныг тунгаан бодох чадвар сул.</li> <li>• Багш монголоор цээж бичиг хийлгэхэд казак хэл рүүгээ буулгаж эгшиг нэмж бичдэг. /эрдэм-эрэдэм, эрхэм – эрэмхэн, бяр – баяр, баяр – баяар, тарвас -гаравас/</li> </ul>
5. Тохируулгат орчин, тодорхой дэмжлэгийн агуулга	<p><u>Сургалтын агуулга, арга зүйн өөрчлөлт, тохируулга (хэрэглэгдэхүүн сонголт орно)</u></p> <ul style="list-style-type: none"> <li>• Хамгийн эхний ширээнд суулгадаг болсон.</li> <li>• Аав ээжтэй нь хамтраад харааг нь тодорхойлж нүдний шил хийлгэсэн.</li> <li>• Багш өөрт нь зориулж том үсгээр бичсэн хэрэглэгдэхүүн бэлдэж өгдөг.</li> <li>• Ихэвчлэн түүнтэй ярилцаж ойлгосон зүйлсийг нь дэвтэрт нь бичүүлдэг.</li> <li>• Тод өнгөнөөс эхлэн өнгийн цаас ашиглаж нүдлүүлдэг.</li> <li>• Өдөр бүр өнгө нүдлүүлэх хөгжөөнт тоглоом толуулдаг.</li> <li>• Цээжээр бичихдээ өөрөөр нь чангаар хэлүүлж бичүүлдэг.</li> <li>• Алхуулах, дуулуулах, зурган карт ашиглан 3, 4-ийн хүрд цээжлүүлдэг.</li> <li>• Хүрдийг сонгох, өөрөөр нь давтан хэлүүлэх аргаар цээжлүүлдэг</li> <li>• Хичээл дээр нь байнга монголоор яриулдаг.</li> <li>• 2, 3-н үетэй үгийг хичээлийн бус цагаар болон гэрт нь даалгавар өгдөг.</li> <li>• Үлгэрийн ном байнга уншуулдаг.</li> </ul>
	<p><u>Барилга байгууламжтай холбоотой өөрчлөлт, тохируулга</u></p> <p><i>Тусгай кабинет байгуулсан. Өнгийн карт, дүрс, хурц өнгөтэй баримлын шавар зэрэг хэрэглэдэхүүнийг бэлдсэн. Хичээлийн 4 байрны гадна талд налуу зам хийсэн</i></p>



	<p>Орчин тойрон (Ангийн хүүхдүүд, бусад багш нар, эцэг эх зэрэг)-той холбоотой авч хэрэгжүүлсэн арга хэмжээ.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хүүхэд нь сайжирч байгаа мэдээг байнга эцэг эхэд нь мэдэгддэг болсноор жилд 1 удаа ярих юмуу ирж уулздаг байсан бол одоо 7 хоног бүр багштай нь боломж гарвал ирж уулзаж, утсаар ярьдаг болсон.</li> <li>• Ангийн хүүхдүүдэд нь илүү дотно найзлахыг зөвлөдөг.</li> <li>• Туслах хичээл орж буй багш нарт нь тухайн хүүхдийн онцлогийг тайлбарлаж өгснөөр багш нарын арга зүй өөрчлөгдөж байгаа .</li> </ul>
	<p><u>Бусад</u></p> <ul style="list-style-type: none"> <li>• Эцэг эхэд нь охиндоо өөрийг нь анхаарч байгааг ойлгуулахын тулд өдөр бүр ярилцаж байхыг зөвлөсөн.</li> <li>• Аль болох гэртээ монголоор ярьж байх.</li> </ul>
<p>6. Хийгдсэн үйл ажиллагааны үр дүн, сайжруулах санал</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Ангийн сурагчдаасаа хоцрохоо больсон. /багш намайг ангийн сайн сурагчийн нэг болж байгаа гэж эцэг эх, сурагчийн хамтарсан хурал дээр хэлсэн /</li> <li>• Заавал самбарт байгаа зүйлсийг бичихгүйгээр тусгайлан бэлдсэн хэрэглэгдэхүүн ашигладаг болсон.</li> <li>• Тод өнгүүдийг ялгаж сурсан, одоо завсрын өнгө болон дүрс ялгаж сурч байгаа.</li> </ul> <div style="display: flex; justify-content: space-around;">   </div> <ul style="list-style-type: none"> <li>• Дүрслэх урлаг, баримлын шавраар бүтээл хийх дуртай болсон.</li> <li>• Эцэг эхтэй нь хамтран харааны үзүүлэлтийг нь тогтоож яг өөрт нь тохирсон шил авч өгсөн.</li> <li>• Цээж бичиг хийлгэхдээ өөрөөр нь чангаар хэлүүлж бичүүлвэл алдаа бага гаргадаг болсон.</li> </ul> <div style="display: flex; justify-content: space-around;">    </div>


	<ul style="list-style-type: none"> <li>• Ангид байгаа хүрдээ сайн харж чадахгүй байгаа учир дандаа хэлж чээжлүүлж нэг нэгээр алхах тоглоом тоглуулж хүрдийг цээжлүүлсэн.</li> </ul> <div style="display: flex; justify-content: space-around;">   </div> <ul style="list-style-type: none"> <li>• Багш болон ангийн сурагчидтайгаа хамтран харилцан яриа байнга өрнүүлж хөгжилддөг болсон.</li> <li>• Эцэг эх нь ангийн хурал болон багштай ирж уулздаггүй байсан бол 7 хоногт багш 1 удаа эцэг эхтэй нь уулзаж ярилцаж хүүхдийнх нь сайжирч байгааг хэлэхэд баярладаг.</li> </ul>
<p>7. Үр дүнг эргэн харж дүгнэсэн АУБ-ийн сэтгэгдэл</p>	<p>Төсөлд хамрагдахаас өмнө би казак хүүхэд учраас монгол хүүхдүүдтэй ярилцахад төвөгтэй, хүрдээ ерөөсөө чээжлээгүй, өнгө ялгаж чаддаггүй, самбарт бичсэн зүйлийг харж бичиж чаддаггүй, дүрс мэддэггүй, унших болон цээжээр бичиж чаддаггүй ангийн хамгийн сул сурагч байсан.</p> <p>Төсөлд хамрагдсны дараа:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Багшаасаа ойлгохгүй байгаа зүйлээ асуудаг болсон.</li> <li>• Өнгө ялгаж сурсан.</li> <li>• Дугуй, гурвалжин дүрсийг ялгаж сурсан.</li> <li>• Чээж бичиг хийлгэхэд бүгдийг алддаг байсан бол одоо талыг нь зөв бичдэг болсон.</li> <li>• Баримлын шавраар маш гоё бүтээлүүд хийдэг болсон.</li> <li>• Бүтээлч сэтгэлгээтэй болсон гэх мэт сайн үр дүн их гарч байгаа. Хамгийн гол нь аав ээж нь ажил ихтэй гэж хэлээд ирж уулздаггүй байсан бол одоо өөрийн биеэрээ ирж уулзаж хуралд байнга ирдэг болсон. Хүүхдийнхээ сайжирч байгааг хараад маш их баяртай байна манай хүүхэд юунд хамрагдаад ийм сайн болоод байна гэж хүртэл ярьж байсан.</li> </ul>

## ХҮҮХДЭД ИЛРЭХ БЭРХШЭЭЛ




### 5 Тоо бодох

1. Анги	2 дугаар ангийн сурагч
2. Хэрэгжүүлэх хугацаа	2018.11-2019.05
3. Хүүхдийн онцлог, хичээл дээр тохиолддог бэрхшээл	<ul style="list-style-type: none"> <li>• 10 дотор цээжээр бодохдоо алддаг /Хуруу оролцуулахгүйгээр/</li> <li>• Үйлдлийн дарааллаа буруу тодорхойлдог.</li> <li>• Баганан бичиглэл хийхдээ орон алдаж бичдэг.</li> <li>• Санасан болон шилжүүлсэн оронгоо мартдаг.</li> <li>• Өгүүлбэртэй бодлого бодож чаддаггүй.</li> </ul>
4. Байж болох шалтгаан	<ul style="list-style-type: none"> <li>• Хичээл байнга тасалдаг учир хоцрогдол үүсдэг.</li> <li>• Тооны утгыг ойлгодоггүй.</li> <li>• Төсөөлөн бодох чадвар сул.</li> <li>• Алийг нь түрүүлж хийх ёстойг ойлгохгүй байх.</li> <li>• Өөрийн хийж чадах үйлдлээ түрүүлж хийдэг учраас үйлдлийн дарааллаа алдаж хийдэг.</li> <li>• Тоо бодохдоо анхаарлаа бүрэн төвлөрүүлдэггүй.</li> <li>• Өгүүлбэртэй бодлогыг уншаад ойлгодоггүй, зураглал хийж чадахгүй.</li> </ul>
5. Тохируулгат орчин, тодорхой дэмжлэгийн агуулга	<p><u>Сургалтын агуулга, арга зүйн өөрчлөлт, тохируулгаас:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>• Багшид ойр байлгах үүднээс салааны эхний ширээнд тэргүүний сурагчтай хамт суулгах.</li> <li>• 10 дотор чөлөөтэй нэмж хасах үйлдэл хийлгэж хэвшүүлэх</li> <li>• Үйлдлийн гишүүдийг нэрлэж сургах.</li> <li>• Цифрийн зөв бичиглэл хэвшүүлэх.</li> <li>• Үйлдлийн дараалал зөв тодорхойлж бодолт хийж сурах.</li> <li>• Өгүүлбэртэй бодлогыг уншаад ойлгодог болгох /зураглал, товч бичиглэл хийж сурах/.</li> </ul>
	<p><u>Барилга байгууламжтай холбоотой өөрчлөлт, тохируулга</u></p> <ul style="list-style-type: none"> <li>• ЛСА “Тэгш хамран сургах” төслийн хүрээнд тохируулгат орчин бүрдүүлж “Хүүхэд хөгжлийн төв”-ийг байгуулав.</li> </ul>
	<p><u>Орчин тойрон (Ангийн хүүхдүүд, бусад багш нар, эцэг эх зэрэг)-той холбоотой авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>• Ангийн шилдэг сурагчтай хамт суулган хяналт, шаардлага тавиулах, чадаж байгаа зүйлийг нь сайшаан урамшуулах.</li> <li>• Гарсан ахиц амжилтыг анги нийтэд нь мэдээллэн урамшуулж хэвших.</li> <li>• Хичээлийн цагийн турш ямар дасгал ажилласан болон юуг хийгээгүй үлдээсэн тухай асран хамгаалагчдад нь тогтмол мэдээллэж хамтарч ажиллах.</li> </ul>

	<p><u>Бусад</u></p> <ul style="list-style-type: none"> <li>• Эцэг эхтэй нь уулзаж хичээл яагаад таслуулдаг талаар ярилцаж түүнийг нь багасгах арга зам боломжийн талаар ярилцав.</li> <li>• Аав нь хөдөө ажлаар явдаг, ээж нь нялх хүүхэдтэй хүргэж өгөх авах хүнгүй учир таслуулдаг гэв.</li> <li>• Хичээл таслалтыг багасгах үүднээс гэрт нь ойрхон байдаг ангийн найзтай нь хамт явуулж байхаар болсон.</li> </ul>
<p>6. Хийгдсэн үйл ажиллагааны үр дүн, сайжруулах санал</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Хичээл сургалтын явцад хяналт тавьж ажиглахын тулд эхний ширээнд суулгасан. Ингэснээр хамт суудаг сурагчаар шаардлага тавиулан, ойлгохгүй байгаа зүйлийг нь заалгах, хичээл хийж байгаа эсэхийг хянаж хичээлийн цагийг зүгээр сууж өнгөрүүлэхгүй байх тал дээр анхаарч ажилласан.</li> </ul>  <ul style="list-style-type: none"> <li>• Савх, шагай ашиглан 10-ын дотор алдаагүй нэмж хасах үйлдлийг хийлгэж сургасан.</li> <li>• Цээжээр бодох чадварыг нэмэгдүүлэх үүднээс гарын арван хурууг ашиглан бодуулж сургасан. Жишээлбэл : 7 дээр хэдийг нэмэхэд 10 болох вэ? гэсэн тоог цээжээр бодуулахдаа гарын 7 хурууг гаргахад цаана нь хэдэн хуруу үлдэх вэ? гэдэг дээр тулгуурлан 10 дотор чөлөөтэй нэмж хасч сурсан.</li> </ul>  <ul style="list-style-type: none"> <li>• Энгийн илэрхийлэл, хаалттай тоо, 4 үйлдлийн давхцсан тоон илэрхийллийг олон удаагийн давтамжтайгаар бодуулж сургасан. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Эхлээд үйлдлийн дараалал бичүүлэх.</li> <li>• Алдааг нь өөрөөр нь дахин засуулах.</li> <li>• Дарааллаа зөв тогтоосны дараа бодолт хийлгэж хэвшсэн.</li> </ul> </li> </ul>



- Цифрийн зөв бичиглэл хийлгэж сургасан. /нэг нүдэнд нэг цифр/



- Орон ангийн задаргаа хийлгэж аравт нэгжийн утгыг таниулсан. /Савх ашиглан аравтыг багцлан нэгтгээд задгай үлдсэн нь нэгж болно/.



- Өгүүлбэртэй бодлогын өгүүлбэрийг тусгайлан бэлтгээд дэвтэрт нь нааж дараа нь ямар бодлогыг яаж бодсон байгааг эргэн харах боломжтой болгож өгсөн




	<p>Өгүүлбэртэй бодлогын өгөгдлийг тодруулан дахин уншуулж товч бичиглэлийн зураглал хийлгэж сургасан.</p> <p>Өгүүлбэртэй бодлогыг бодуулахдаа гол нөхцөл агуулгыг ойлгуулах, юу олох гэж байгааг яаж олохыг сурагч ойлгосон байх нь чухал.</p>
<p>7. Үр дүнг эргэн харж дүгнэсэн АУБ-ийн сэтгэгдэл</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Сурагч “Н”-ээс 2018.11.20 нд асуулга авахад “Тоо бодох” хэсгийн бүх асуулгад “Огт чадахгүй – 1” гэсэн оноо авсан учир тоо бодох чадварыг нэмэгдүүлэх тал дээр илүү анхаарч ажилласан.</li> <li>• SEN арга зүйн зөвлөмжийн дагуу “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө” боловсруулж ажилласны үр дүнд тухайн сурагчид богино хугацаанд ахиц гарч байгаа нь ажиглагдаж байсан. Үүнд :             <ul style="list-style-type: none"> <li>- Хичээл хийх хүсэл эрмэлзэлтэй болж гэрийн даалгавар хийх, хичээлд оролцох оролцоо идэвх нэмэгдсэн.</li> <li>- Тооны утгыг ойлгож цээжээр бодох чадвартай болсон</li> <li>- Үйлдлийн гишүүдийг ойлгож мэдсэнээр илэрхийлэл бодох чадвар маш сайн болж алдсан ч яагаад юун дээр нь алдснаа ойлгох чадвартай болж байна.</li> </ul> </li> <li>• SEN арга зүйн зөвлөмжийн дагуу сурагчтай ажиллахад эцэг эхийн оролцоо сайжирч багштай байнгын холбоотой байж багш болон сургуулийн үйл ажиллагааг дэмждэг болсон.</li> <li>• 2019.04.20 нд асуулгыг дахин авахад дан ганц “Тоо бодох” чадвар нэмэгдээд зогсохгүй бусад чадвар мэдэгдэхүйц сайжирсан байгаа нь SEN арга зүйн зөвлөмж нь багшийн үйл ажиллагааг бодитойгоор дэмжсэн үр дүнтэй хөтөлбөр болсон.</li> </ul>



## ХҮҮХДЭД ИЛРЭХ БЭРХШЭЭЛ

### 5 Тоо бодох



1. Анги	3 дугаар ангийн сурагч
2. Хэрэгжүүлэх хугацаа	2018-2019 хичээлийн жил 2 ба 3-р улирал
3. Хүүхдийн онцлог хичээл дээр тохиолддог бэрхшээл	<ul style="list-style-type: none"> <li>• Орон ангийн ухагдахууныг сайн ойлгодоггүй.</li> <li>• Үйлдлийн дарааллаар бодохдоо ангийн сурагчдын хэмжээнд хараахан хүрээгүй.</li> <li>• Бодлогын нөхцөл, асуултыг ялгаж ойлгохдоо тааруухан.</li> </ul>
4. Байж болох шалтгаан	<ul style="list-style-type: none"> <li>• Бүх зүйлийг эхнээс нь бичдэг гэсэн ойлголт тогтсон учраас багана бичиглэлээр бодохдоо орон ангийг буруу бичиж, боддог.</li> <li>• Эцэг эх нь хүүхэддээ зааж ойлгуулах арга дутмаг. Анхаарал халамж хангалтгүй.</li> <li>• Анхаарал төвлөрөлт удаан биш сарнимтгай.</li> <li>• Бусдын анхаарлыг өөртөө хандуулах дуртай учраас янз бүрийн үйлдэл авиа гаргадаг</li> </ul>
5. Тохируулгат орчин тодорхой дэмжлэгийн агуулга	<p>Сургалтын агуулга, арга зүйн өөрчлөлт, тохируулга</p> <ul style="list-style-type: none"> <li>• Орон ангийн ухагдахууныг ойлгуулахын тулд а. Ижил өнгийн будаг, харандаа, STEM сургалтын блок зэрэг биет хэрэглэгдэхүүнийг нэгтгэн багцалж, тоолуулж бодуулдаг байлаа.</li> </ul> <div style="display: flex; justify-content: space-around;">  </div> <p>Б. Ангид эгнээгээр тавьсан ширээг нэгж, аравт, зуутаар нэрлэж самбарын дээр байрлуулж хичээлийн эхэнд сануулдаг.</p>



Зуут Аравт Нэгж

В. Оронгийн нэрийг тогтоосны дараа бичих гэж байгаа тоог цифрийн тоогоор цэглүүлж нэгжийн орноос эхлэн бичүүлж

бодуулдаг.(багш самбарт дагуулан бичдэг.




Г. Хамт сууж байгаа сурагчтайгаа тооны бичилтээ тохируулдаг.



- Үйлдэл хавсарсан илэрхийллийг бодуулахдаа А. үзүүлэнг ашиглан дугаарлуулна.

( )	x	+
	÷	-

Б. Дугаарын дагуу эхнээс нь бодож, ашигласан дугаарыг дугуйлна.





- Бодлогын нөхцөл асуултыг ойлгуулахын тулд
  - А. Бодлогын олох хэсэг буюу асуултыг тодруулна.
  - Б. Товч бичиглэлээр бичсэн бодлогыг зохиолгож уншуулна.
  - В. Бодолт хийлгэж олж байгаа зүйлийн нэрийг бичүүлдэг.

									
	<p>Орчин тойрон</p> <ul style="list-style-type: none"> <li>Хичээл дээр болон гэртээ хийсэн зүйлүүдээ дэвтрээ сольж шалгаж, алдаагаа засдаг</li> <li>Зарим хүндэвтэр илэрхийлэл болон бодлогыг өөрөө бие даан бодсоны дараа багшийн бодсонтой тулгаж засдаг.</li> <li>Илэрхийлэл бодох 5-10 хоногийн аян, түргэн бодогч зэрэг уралдаануудыг зохиодог</li> <li>Хичээлийн төгсгөлд нэг илэрхийллийг заавал зөв бодож үзүүлсний дараа дэвтэрт тэмдэглэгээ хийлгэн явдаг.</li> </ul> <table border="1" data-bbox="434 712 1174 776"> <tr> <td>8</td> <td>Тэнгис</td> <td>24</td> <td></td> <td>27</td> <td>23</td> <td>31</td> <td>30</td> </tr> </table> <ul style="list-style-type: none"> <li>Чадахгүй зүйлээ ангийн хамт олноороо тайлбарлуулж бичиж авдаг.</li> <li>Эцэг эхэд 14 хоногт нэг удаа арга зүйн зөвлөгөө өгдөг.</li> </ul>	8	Тэнгис	24		27	23	31	30
8	Тэнгис	24		27	23	31	30		
<p>6. Хийгдсэн үйл ажиллагааны үр дүн, сайжруулах санал</p>	<ul style="list-style-type: none"> <li>Илэрхийлэл бодох чадвар дээшилж, ангийн гүйцэтгэл 88%-д хүрсэн.</li> <li>Бодлогын нөхцлийг товч бичиглэл хийхээс гадна ямар аргаар бодож болохыг ярилцаж, боддог болсон.</li> <li>Бодлогын үйлдлийг гүйцэтгэж, олж байгаа зүйлийнхээ нэрийг заавал бичдэг.</li> </ul>  <ul style="list-style-type: none"> <li>Мөн товч бичиглэлд олсон зүйлээ орлуулан бичиж сурсан.</li> </ul>								
<p>7. Үр дүнг эргэн харж дүгнэсэн анги удирдсан багшийн сэтгэгдэл</p>	<ul style="list-style-type: none"> <li>Хялбар аргаар тохирох хэрэглэгдэхүүнийг сонгож, заахад хүүхэд бүр илэрхийлэл болон бодлого бодох сонирхолтой болдог.</li> <li>Анги танхимд байгаа зүйлүүдийг ашиглан өдөр тутам хичээлдээ хэрэглэх нь тэдэнд ойр байдаг.</li> <li>Гарын хурууг ашиглан уртын ба хүндийн хэмжүүрүүдийн холбоо хамаарлыг ойлгуулахад хялбар байсан.</li> <li>Анги хамт олноороо математикийн хичээлдээ илүү идэвхтэй болж ангийн гүйцэтгэл эрс сайжирсан.</li> </ul>								

## ХҮҮХДЭД ИЛРЭХ БЭРХШЭЭЛ

### ⑥ Цаг хугацаа, орон зай, учир шалтгааны холбоо хамаарлыг ойлгох

1. Анги	8 дугаар ангийн сурагч
2. Хэрэгжүүлэх хугацаа	2018 оны 11 сараас 2019 оны 3 сар
3. Хүүхдийн онцлог, хичээл дээр тохиолддог бэрхшээл	Багаар ажиллах чадвар сул, дүрмээ баримталж тоглож чаддаггүй. Түр өгч байгаач, баярлалаа, уучлаарай гэх мэт үгийг зөв хэрэглэж чаддаггүй.
4. Байж болох шалтгаан	<ul style="list-style-type: none"> <li>Харилцагчдынхаа дохиог ойлгодоггүй, нүүрний хувирал, сэтгэл хөдлөл зэргийг уншиж ойлгож чаддаггүй.</li> <li>Найзтайгаа хэрхэн харьцахаа мэдэхгүй.</li> </ul>
5. Тохируулгат орчин, тодорхой дэмжлэгийн агуулга	Хялбар дүрэмтэй тоглоомоос эхлүүлье - багш оролцоно <b>Багийн дүрэм журам, үүрэг хариуцлагыг багаараа хамтран өөрсдөө зохиож туршиж үзсэн.</b>
	Харилцагч нь ямар царай гаргавал уурлах вэ? гэх мэтээр бусдын сэтгэл хөдлөлийн байр байдлыг ажиглах.
	Ямар нэг хэцүү зүйл гарвал багшдаа хэлэх тухай хүүхдэд хэлж ойлгуулах. <b>Тулгарсан бэрхшээлээ багш болон багийнхандаа хэлж, хамт зөвлөлдөж шийдвэр гаргах арга барилд сургах зэрэг ажлуудыг зохион байгуулсан.</b>
6. Хийгдсэн үйл ажиллагааны үр дүн, сайжруулах санал	<ul style="list-style-type: none"> <li>Тус сурагч нь бусдыг сонсох, бусадтай санал бодлоо хуваалцах, хамтын шийдвэр гаргах, бусадтай зөв харилцах, тоглоомын дүрмийг баримтлан тоглохыг ойлгосон.</li> <li>Баярлалаа, Уучлаарай, Түр өгч байгаач зэрэг үгсийг зөв хэрэглэж сурсан.</li> <li><b>Сайжруулах зүйл</b></li> <li>Харилцагчдынхаа нүүрний хувирал, сэтгэл хөдлөл зэргийг сайн уншиж ойлгож чадахгүй байгааг залруулах шаардлагатай.</li> </ul>
	 


	
<p>7. Үр дүнг эргэн харж дүгнэсэн АУБ-ийн сэтгэгдэл</p>	<p>АУБ нь энэ багт ажиллаагүй гэв.</p>

## ХҮҮХДЭД ИЛРЭХ БЭРХШЭЭЛ

⑥ Цаг хугацаа, орон зай, учир шалтгааны холбоо хамаарлыг ойлгох

⑧ Хүнтэй харилцах харилцаа


1. Анги	6 дугаар ангийн сурагч
2. Хэрэгжүүлэх хугацаа	2019 оны 1 сарын 22-ноос 6 сар хүртэл
3. Хүүхдийн онцлог, хичээл дээр тохиолддог бэрхшээл	Ойлголт удаан, хэлж байгаа зүйлийг ойлгоод, шууд дэвтэрт буулган бичих чадвар сул, нээлттэй ярилцах өөрийгөө илэрхийлэх, бие дааж хичээл хийх чадвар сул, танин мэдэхүйн түвшин дундаж.
4. Байж болох шалтгаан	Тархины гэмтэл, сул хараатай, тоо бодох хичээлдээ дуртай боловч унших чадвар муу учраас даалгаврыг хурдтай гүйцэтгэх боломж муу.
5. Тохируулгат орчин, тодорхой дэмжлэгийн агуулга	<ul style="list-style-type: none"> <li>• Ангийн бусад хүүхдүүдээс ялгалгүй ижил агуулгатай хичээлийг илүү хөнгөн болгож орох. (ингэснээр тухайн хүүхэд ангийнхантайгаа хамтарч ажиллах чадвар сууж хоцрогдол бага үүснэ)</li> <li>• тухайн хүүхэд маань маш хариуцлагатай хичээл зүтгэлтэй тул энэхүү зан чанарыг нь ашиглан хичээлээр олж авсан мэдлэгээ амьдрал дээр яаж хэрэглэж болохыг ойлгуулах, даалгаврыг өгөх (жишээлбэл, 1000 төгрөгөөр хэр их юм авч болох вэ? Авч ирсэн тоо ширхгээр нь урамшуулах.</li> <li>• Гэр бүлийн гишүүдийн нас нийлээд дундаж нь хэд байна вэ? Ямар багшийн хичээл илүү сонирхолтой вэ? диаграммаар дүрслэж үзүүлэх, танай гэрт хэдэн гурван өнцөгт, хэдэн дөрвөн өнцөгтэй тавилга байна вэ? Тоог нь гаргах гэх мэт)</li> <li>• Дүнгээр байнга урамшуулан сайшаах магтах.</li> </ul>





СУРАЛЦАХУЙН БЭРХШЭЭЛТЭЙ, ЗАН ҮЙЛИЙН АСУУДАЛТАЙ ХҮҮХДЭД  
ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ АРГА ЗҮЙН ЗӨВЛӨМЖ

	  <p>Математик Монгол улсын гавьяат багш Д.Батсуурийн нэрэмжит "Титэн" ерөнхий боловсролын сургуулийн 6д ангийн сурагч Д.Исаагийн</p>
	<p>Хамгийн урд суулгах, зарим тохиолдолд өөрийнхөө хажууд суулган хичээлд оролцуулдаг ингэснээр тухайн хүүхдийн анхаарал хичээлд төвлөрч, багштай ярьж ойлголцоход нь дөхөмгэй байдаг.</p>
	<p>Ангийн хүүхдүүдтэй илүү их хамтарч ажилладаг, учир нь хүүхдүүдтэй нэг баг болж ажиллах нь хичээлээс гадуурх нийгмийн идэвхийг сайжруулж өгдөг. (сайн найзтай нь хамт самбарт тоо бодуулах, давтлага болон завсарлагааны цагаар хамт тоглох, ангийн хүүхдүүдийн сэтгэлийн үгийг хэлүүлж урам хайрлах, анги хамт олон бүгд нэг хүн шиг нэгнээ ойлгох ёстойг ойлгуулан хөгжөөнт тоглоом тоглуулах, дасгал хийлгэх, алтан хонх тэмцээн зохиодог)</p>
	<p>Ангийн охидуудтай ярилцаж ялгаварлан гадуурхалгүй хичээлд нь тусалж байх талаар зөвлөгөө өгөх.</p>

<p>6. Хийгдсэн үйл ажиллагааны үр дүн, сайжруулах санал</p>	<ul style="list-style-type: none"><li>• Үг дуу цөөтэй байсан, харин маш их нээлттэй болсон</li><li>• Ойлгохгүй байгаа зүйл, хичээлээ асуудаг.</li><li>• Багшдаа хайртай гэж хэлдэг, хамт олонтойгоо нийтэч дотно болсон.</li><li>• Хүрдээ цээжилсэн.</li><li>• 1000- ын дотор чөлөөтэй нэмж, хасдаг.</li><li>• Хамгийн их өөрчлөлт бол, багштайгаа илүү ойр дотно, нээлттэй болсон, цаашид хамтдаа хичээх, өөрийгөө хөгжүүлж мэдлэг олж авах арга замыг нь гэрэлтүүлсэн.</li></ul> 
<p>7. Үр дүнг эргэн харж дүгнэсэн АУБ-ийн сэтгэгдэл</p>	<ul style="list-style-type: none"><li>• Манай ангийн сурагч нь анх ирж байсан үеээсээ маш их өөрчлөлт гарсан. Харилцааны хувьд нөхөрсөг анги хамт олонтойгоо байх дуртай олон нийтийн ажилд идэвхтэй оролцдог. Багш нартайгаа нээлттэй харилцдаг өөрийн санаа бодлоо багшдаа болон найздаа чөлөөтэй илэрхийлж чаддаг болсон. Дизайн технологи, математик зэрэг хичээлүүддээ их дуртай.</li></ul>

## ХҮҮХДЭД ИЛРЭХ БЭРХШЭЭЛ

### ⑦ Булчингийн хөдөлгөөн /Бодит хэрэгжүүлсэн жишээ байхгүй/

1. Анги	
2. Хэрэгжүүлэх хугацаа	
3. Хүүхдийн онцлог, хичээл дээр тохиолддог бэрхшээл	
4. Дээрх бэрхшээл үүссэн болох шалтгаан	
5. Тохируулгат орчин тодорхой дэмжлэгийн агуулга	



6. Хийгдсэн үйл ажиллагааны үр дүн, сайжруулах санал	


7. Үр дүнг эргэн дүгнэсэн АУБ-ийн сэтгэгдэл	
---	--


## ХҮҮХДЭД ИЛРЭХ БЭРХШЭЭЛ

9а) Үйлдэл хийх /Анхаарал сарних/

9б) Үйлдэл хийх /Хэт хөдөлгөөнтэй/

1.	Анги	11 дүгээр ангийн сурагч														
2.	Хэрэгжүүлэх хугацаа	2018.11.05-2019.05.20.														
3.	Хүүхдийн онцлог, хичээл дээр тохиолддог бэрхшээл	Хичээлийн хоцрогдолтой учир хичээлд идэвх муутай, зорилгогүй, цаг баримталдаггүй, хичээл тасалдаг, ичимхий бүрэг зантай, дуу цөөтэй.														
4.	Байж болох шалтгаан	<ul style="list-style-type: none"> <li>• Цагийн менежментгүй.</li> <li>• Хичээлийн бус цагаар цахим орчинд цагаа их өнгөрүүлдэг.</li> <li>• Мэргэжил сонгоогүй, хариуцлага сул.</li> <li>• Дүрэм баримтлах, багаар ажиллах чадвар сул.</li> </ul>														
		<p><b>2-р улирал</b> Хийгдсэн үйл ажиллагаа:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Цаг баримталдаг болгох зорилгоор: - Өдрийн тэмдэглэл хөтлүүлсэн. Багш өдрийн тэмдэглэл хөтлөх дэвтэр авч өгч, хэрхэн хөтлөх талаар заавар өгч, өдрийн тэмдэглэл хөтлүүлсэн.</li> </ul> <div style="display: flex; justify-content: space-around;">   </div> <table border="1" style="width: 100%; text-align: center;"> <thead> <tr> <th>Цаг Гараг</th> <th>8:00- 13:15</th> <th>13:30- 15:30</th> <th>16:30- 18:00</th> <th>18:30- 19:30</th> <th>19:30- 21:00</th> <th>21:00 цагаас хойш</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Даваа</td> <td style="background-color: yellow;"></td> <td style="background-color: purple;"></td> <td style="background-color: blue;"></td> <td style="background-color: brown;"></td> <td style="background-color: pink;"></td> <td></td> </tr> </tbody> </table> <ul style="list-style-type: none"> <li>• Хичээлтэй цаг</li> <li>• Жишиг даалгавар хийх /бие даалт/</li> <li>• Дугуйлан</li> <li>• Амрах цаг</li> <li>• Хичээл давтах /даалгавраа хийх/</li> <li>• Чөлөөт цаг</li> </ul>	Цаг Гараг	8:00- 13:15	13:30- 15:30	16:30- 18:00	18:30- 19:30	19:30- 21:00	21:00 цагаас хойш	Даваа						
Цаг Гараг	8:00- 13:15	13:30- 15:30	16:30- 18:00	18:30- 19:30	19:30- 21:00	21:00 цагаас хойш										
Даваа																

### Сурагчийн өөрийн төлөвлөгөөний хуудас



-Өдрийн ажлын төлөвлөгөө боловсруулсан. Өдөр бүр гэрийн даалгавар хийх, бие даалт, жишиг даалгавар гүйцэтгэх хугацаагаага төлөвлөж, төлөвлөгөөний дагуу хичээллэсэн.

- **Хичээлийн хоцрогдолгүй болгох:**

- II улирлаар судлах хичээл тус бүр дээр сурагч өөрийн зорилгоо тодорхойлж, ойрын төлөвлөгөө гаргасан.
- Өдөр бүр гэрийн даалгавар хийх, бие даалт, жишиг даалгавар гүйцэтгэх хугацаагаага төлөвлөж, төлөвлөгөөний дагуу хичээллэсэн.




Цаг Гарг	8:00- 13:15	13:30- 15:30	16:30- 18:00	18:30- 19:30	19:30- 21:00	21:00 цагаас хойш
Даваа						

- Хичээлтэй цаг
- Жишиг даалгавар хийх /бие даалт/
- Дугуйлан
- Амрах цаг
- Хичээл давтах /даалгавраа хийх/

- **Мэргэжил сонголт:**

- Тухайн сурагчаас мэргэжлийг нь тодорхойлох зорилгоор судалгаа авч, боловсруулалт хийсэн. 7 багц чадвараас хамгийн сайн гүйцэтгэдэг чадварыг нь тодорхойлсон.
- Ямар мэргэжил тухайн сурагчид тохирох эсэхийг тодорхойлсон.
- Өөрийн сонирхсон 5 мэргэжлийн ирээдүйн эрэлт хэрэгцээ, давуу болон сул талыг тодорхойлсон.




<p>5.</p>	<p>Тохируулгат орчин, тодорхой дэмжлэгийн агуулга</p>	<table border="1" data-bbox="557 232 1161 540"> <tr> <td>Чадвар</td> <td>Н буюу туслалцаа зөвлөгөө үзүүлдэг тэдэнтэй ажиллахтай холбоотой сонирхлууд</td> </tr> <tr> <td>Сонирхол</td> <td>Хүмүүстэй ажиллахтай холбоотой сонирхлууд</td> </tr> <tr> <td>Хөдөлмөрийн салбар</td> <td>Маркетинг, авлал жуучлал, батлан хамгаалаа, урлаг дизайн, фото зураг, компьютер мэдээлэл хэрэгсэл, хувь хүнд чиглэсэн үйлчилгээ</td> </tr> <tr> <td>Мэргэжил</td> <td>Армийн офицер, улсын байцаагч, урлагийн мэргэжилтэн, хөгжмийн мэргэжилтэн мэдээллийн сан, төстийн инженер</td> </tr> </table>   <p>- Дүрэм баримтлах, багаар ажиллах чадварыг сайжруулах зорилгоор багийн 4 гишүүн тогтсон хугацаанд ном уншуулж, тухайн номыг уншсанаар өөрт төрсөн сэтгэгдэл, эргэцүүлэл бичиж багаараа санаа бодлоо солилцож, хэлэлцүүлэг хийв.</p>  <ul style="list-style-type: none"> <li>• <b>Хэрэглэгдэхүүн сонголт :</b> Ш. Ичинхорлоо “ Хүний хөгжил” Шон Кови “Өсвөр насныхны дээдэлж мөрдөх 7 зуршил”</li> </ul>	Чадвар	Н буюу туслалцаа зөвлөгөө үзүүлдэг тэдэнтэй ажиллахтай холбоотой сонирхлууд	Сонирхол	Хүмүүстэй ажиллахтай холбоотой сонирхлууд	Хөдөлмөрийн салбар	Маркетинг, авлал жуучлал, батлан хамгаалаа, урлаг дизайн, фото зураг, компьютер мэдээлэл хэрэгсэл, хувь хүнд чиглэсэн үйлчилгээ	Мэргэжил	Армийн офицер, улсын байцаагч, урлагийн мэргэжилтэн, хөгжмийн мэргэжилтэн мэдээллийн сан, төстийн инженер
Чадвар	Н буюу туслалцаа зөвлөгөө үзүүлдэг тэдэнтэй ажиллахтай холбоотой сонирхлууд									
Сонирхол	Хүмүүстэй ажиллахтай холбоотой сонирхлууд									
Хөдөлмөрийн салбар	Маркетинг, авлал жуучлал, батлан хамгаалаа, урлаг дизайн, фото зураг, компьютер мэдээлэл хэрэгсэл, хувь хүнд чиглэсэн үйлчилгээ									
Мэргэжил	Армийн офицер, улсын байцаагч, урлагийн мэргэжилтэн, хөгжмийн мэргэжилтэн мэдээллийн сан, төстийн инженер									
<p>6.</p>	<p>Хийгдсэн үйл ажиллагааны үр дүн, сайжруулах санал</p>	<p>-Цагийн төлөвлөлт хийж сурсан. -Ном уншиж, оюун дүгнэлт хийдэг болсон. -Ирээдүйн мэргэжлийнхээ чиг хандлагыг тодорхойлсон. -Санал бодлоо илэрхийлэх, багаар ажиллах чадварт ахиц гарч байгаа.</p>								



7.	Үр дүнг эргэн харж дүгнэсэн АУБ-ийн сэтгэгдэл	<ul style="list-style-type: none"><li>- Сурагчийн цагийн ашиглалт сайжирсан. Өдрийн тэмдэглэл хөглөн, өөрийн цагийн хуваарьтай болсон.</li><li>- Хичээл таслахаа больсон.</li><li>- Өөрийн зорилготой болсон.</li><li>- Нээлттэй болж эхэлж байна. Багшдаа санаа бодлоо чөлөөтэй илэрхийлдэг болсон.</li><li>- Мэргэжлийн чиг баримжаагаа тодорхойлсон.</li><li>- Инженер (мэдээлэл харилцааны технологи) болох зорилгоор шугам зураг, мэдээлэл харилцааны технологи, математикийн хичээлдээ илүү анхаарч, судалдаг болж байна.</li></ul>
----	---	---


## ХҮҮХДЭД ИЛРЭХ БЭРХШЭЭЛ

9а) Үйлдэл хийх /Анхаарал сарних/


9б) Үйлдэл хийх /Хэт хөдөлгөөнтэй/

1. Анги	5 дугаар ангийн сурагч
2. Хэрэгжүүлэх хугацаа	2018.11- 2019. 5 сар
3. Хүүхдийн онцлог, хичээл дээр тохиолддог бэрхшээл	Анхаарлын тогтворжилт муу, бие даан аливааг хийх чадвар сул, хүний яриа сонсохгүй байх нь их, өөрийнхөө орчинг цэгцэлж чаддаггүй, хичээл дээр тогтвортой сууж чадахгүй, ангийн ширээ сандал дээр гарах, ангиас зөвшөөрөлгүй гараад гүйчихдэг, ширээн доогуур нуугдан суудаг, гэнэт чангаар дуу дуулах гэх мэт, өөрийн дураараа янз бүрийн үйлдэл хийдэг.
4. Дээрх бэрхшээл үүссэн болох шалтгаан	Ар гэрийн хараа хяналт, халамж сул байдлаас болж хичээлээс хоцрогдсон. Үүний улмаас хичээл хийх сонирхолгүй болсон. Гэрээсээ өглөө эрт гарч гадуур сэлгүүцэх, РС тоглоом тоглох нь ихэссэн.
5. Тохируулгат орчин тодорхой дэмжлэгийн агуулга	<b>Сургалтын агуулга, арга зүйн өөрчлөлт, тохируулга /хэрэглэгдэхүүн сонголт орно/</b>
	<ul style="list-style-type: none"> <li>• Эхний ширээнд суулгасан.</li> <li>• Хажууд нь болон ард нь дотны найз болон хичээлдээ сайн сурагчийг суулган хамт ярилцаж, хичээлийг хамтарч хийх боломжийг олгодог.</li> <li>• Даалгаврыг хийх хугацааг зааж өгч ажиллуулдаг.</li> </ul>
	<b>Барилга байгууламжтай холбоотой өөрчлөлт тохируулга</b> <ul style="list-style-type: none"> <li>• Шаардлагагүй</li> </ul>
	<b>Орчин тойрон /Ангийн хүүхдүүд, бусад багш нар, эцэг эх зэрэгтэй / холбоотой авч хэрэгжүүлсэн арга хэмжээ</b> <ul style="list-style-type: none"> <li>• Сэтгэл зүйчтэй уулзуулан амжилттай суралцах талаар ярилцаж зөвлөгөө өгсөн.</li> </ul>
	
	<ul style="list-style-type: none"> <li>• Сургуулийн найрал дууны дугуйланд явдаг болсон.</li> </ul>

	<p><b>Бусад</b></p> <ul style="list-style-type: none"><li>• Эмээтэйгээ хамт амьдардаг. Эмээ нь ирж уулзах боломжгүй учраас харилцах дэвтэр ажиллуулсан.</li></ul>
<p>6. Хийгдсэн үйл ажиллагааны үр дүн, сайжруулах санал</p>	<ul style="list-style-type: none"><li>• Даалгаврыг богино хэлбэрээр өгдөг болсон.</li><li>• Сууж сургахын тулд хугацаа заан тодорхой хугацаанд суулгах.</li><li>• Зурган даалгавар өгөх.</li><li>• Хийх дуртай зүйл дээр тулгуурлан даалгавар хийлгэх.</li></ul>  <p>The image shows a close-up of a hand pointing to a worksheet. The worksheet contains several diagrams and text in Mongolian. One diagram shows a landscape with a river and trees, labeled 'С.В'. Another diagram shows a similar landscape with a different arrangement of trees, labeled 'С.В'. The text on the worksheet includes 'Хийгдсэн үйл ажиллагааны үр дүн, сайжруулах санал' and 'Хичээлдээ эрт ирдэг учир хичээлийн өмнө болон дараа багштайгаа хамтран ангийн сурагчдын дэвтэр засах, даалгавар шалгах зэрэгт тусалдаг.'</p> <ul style="list-style-type: none"><li>• Хичээлдээ эрт ирдэг учир хичээлийн өмнө болон дараа багштайгаа хамтран ангийн сурагчдын дэвтэр засах, даалгавар шалгах зэрэгт тусалдаг.</li></ul>  <p>The image shows a teacher sitting at a desk in a classroom, writing in a notebook. The teacher is a woman with dark hair, wearing a dark jacket. She is sitting at a desk with a wooden top and metal legs. There are other desks and chairs in the classroom. On the wall behind her, there are several posters and a calendar. A bookshelf is visible on the right side of the image.</p>



Өмнө нь хичээлийг бүрэн гүйцэт бичдэггүй байсан.



Даалгаврыг багасган хугацаа заан хичээллэх болсны үр дүнд өгсөн үүрэг даалгаврыг сайн гүйцэтгэдэг болсон.

7. Үр дүнг эргэн дүгнэсэн АУБ-ийн сэтгэгдэл



Өмнө нь эмх замбараагүй байсан



Хичээлийн дундуур дураараа сэлгүүцдэг байсан.



Дараа нь

Сонгогдсон хүүхэд маань анхаарал сарнимтгай, хэт хөдөлгөөнтэй тогтвортой сууж чаддаггүй байсан. Сууж хичээлээ хийж сургахын тулд дээрх үйл ажиллагаануудыг сонгон ажилласнаар үр дүнд хүрч байгаад нь ангийн багшийн хувьд баяртай байна.

Хамт олон дунд эмх цэгцтэй биеэ зөв авч явахыг сургахын тулд ангийн даргын үүрэг гүйцэтгүүлэн ажилласан. Мөн дуулах дуртай учраас найрал дууны дугуйланд суралцуулж, сэтгэл зүйчтэй уулзуулан арга зүйн зөвлөмж өгсөн нь сурах урам зоригийг төрүүлсэн.

Эцэг эхийн харилцах дэвтэр ажиллуулснаар сурагч маань өглөө эрт ирж сэлгүүцэж РС тоглоом тоглохоо больсон. Багштайгаа ярилцах, номын санд ном унших, дэвтэр засах зэргээр чөлөөт цагаа өнгөрөөдөг болсон. Хичээл дээр сууж чадахгүй босож гүйх, дуулах, хашгирах зэргээр бусдын анхаарлыг өөртөө татах гэж оролддог байсан бол одоо 20-30 минут тогтвортой суун хичээллэж чаддаг болсон.

ISBN 991995195-1



9 789919 951955